

НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Улс	Монгол Улс
Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний хамрах хугацаа	2024-2027
Тайлангийн огноо	2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр

Танилцуулга

Монгол Улс 2013 онд Нээлттэй засгийн түншлэл (НЗТ) олон улсын санаачлагад нэгдсэн бөгөөд энэхүү санаачлагад өнөөдрийн байдлаар 74 орны Засгийн газар болон 150 орон нутгийн засаг захиргаа хамрагдаж байна. НЗТ нь ил тод, иргэдийн оролцоотой, хүртээмжтэй, хариуцлагатай засаглалыг дэмжихийг зорьдог. Сүүлийн 12 жилийн хугацаанд Монгол Улс НЗТ-ийн хүрээнд таван удаагийн Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө (ҮҮАТ) боловсруулсан бөгөөд эдгээр төлөвлөгөө нь 2027 оныг дуустал хэрэгжүүлэх үүрэг амлалтыг хамарч байна. Төлөвлөгөө бүрийн хэрэгжилтийн явц дараах байдлаар үнэлсэн:

ҮҮАТ-I: Нийт 21 үүрэг амлалттай, 3 нь бүрэн хэрэгжсэн, 6 нь бодит үр дүнд хүрсэн.

ҮҮАТ-II: Нийт 13 үүрэг амлалттай, 3 нь бүрэн хэрэгжсэн, 1 нь бодит үр дүнд хүрсэн.

ҮҮАТ-III: Нийт 13 үүрэг амлалттай, 3 нь бүрэн хэрэгжсэн, 2 нь бодит үр дүнд хүрсэн.

ҮҮАТ-IV: Нийт 9 үүрэг амлалттай, 4 нь бүрэн хэрэгжсэн, 1 нь бодит үр дүнд хүрсэн.

Эдгээр үр дүнг НЗТ-ийн Хараат бус тайлагнах механизм (ХБТМ) албан ёсоор баталгаажуулсан болно.

Цаашид Монгол Улс 2024–2027 оны Үндэсний үйл ажиллагааны V төлөвлөгөө (ҮҮАТ-V)-ний хүрээнд 9 үүрэг амлалт хэрэгжүүлэхээ олон улсын хамтын нийгэмлэгт илэрхийлэн, нээлттэй засаглал, эгэх хариуцлагын талаарх өөрийн тууштай байр суурийг нотолж байна. ҮҮАТ-V нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “Алсын хараа–2050”-тай (2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн УИХ-ын 52 дугаар тогтоолоор баталсан) нягт уялдаатай. “Алсын хараа–2050” нь хүн төвтэй, ухаалаг, тогтвортой засаглалыг төлөвшүүлэх, чадварлаг, тогтвортой төрийн албыг бий болгох, иргэдэд чиглэсэн цахим төрийн үйлчилгээг бүрэн хөгжүүлэх, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, хүний эрхийг бүрэн хангах, шударга ёсыг тогтоох, авлигагүй нийгмийг төлөвшүүлэхийг зорьсон. Тус бодлогын 5.5 дугаар зорилт нь төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг бэхжүүлж, үндэсний бодлого боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад оролцогч талуудын оролцоог хангах зохистой тогтолцоог бүрдүүлэхийг тусгасан. Харин 5.6 дугаар зорилт нь авлига, хээл хахуультай тэмцэх боловсролыг нэмэгдүүлэх, шүүх эрх мэдлийн тогтолцоог чадавхжуулах талаар чиглэсэн байна.

Мөн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн УИХ-ын 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 6 дугаар бүлэгт төрийн бүтээмжийг сэргээх зорилт тусгасан бөгөөд дараах чиглэлээр ҮҮАТ-V-тай уялдаж байна. Үүнд төрийн үйлчилгээг цахимжуулах, хүнд суртал, шат дамжлагыг бууруулах, төрийн өмчит компаниудын засаглал, үр ашгийг сайжруулах, төрийн өмчит ААН-ийг олон нийтийн хяналтад оруулах зэрэг багтсан. Монгол Улсын ҮҮАТ-V нь НЗТ-ийн хамтран бүтээх шалгуурыг бүрэн хангасан бөгөөд нийгмийн бүх талын төлөөллийг хамарсан, ил тод, хамтын оролцоотой хэлэлцүүлгийн үндсэн дээр боловсруулсан. Мөн тус ҮҮАТ-V шинэчлэх явц 2025 оны намар төлөвлөгдсөн байна.

Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний явц

Монгол Улсын 2024–2027 оны Үндэсний үйл ажиллагааны V төлөвлөгөөг (ҮҮАТ V) боловсруулан танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 99 дүгээр тушаалаар баталсан. Ажлын хэсэгт нийт 52 гишүүн багтсан бөгөөд үүнээс 28 нь (54%) төрийн байгууллагын төлөөлөл, 24 нь (46%) төрийн бус байгууллагын төлөөлөл байв. Ажлын хэсгийн гишүүдийг НЗТ-ийн зарчим, үйл явцын талаарх үндсэн ойлголтоор хангах зорилгоор Ази, Номхон далайн бүсийг хариуцагч Ивигайл Онг, Хараат бус тайлагнах механизмыг (ХБТМ) хариуцсан судлаач Сара Жэйкобс нарын дэмжлэгтэйгээр суурь сургалт, зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан.

Ажлын хэсгийн анхны хуралдааныг 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулж, ҮҮАТ V-ийн анхны төслийг хэлэлцэж, өмнөх ҮҮАТ IV-д тусгасан ч хэрэгжээгүй үүрэг амлалтын хэрэгжилтийг дүгнэв. Энэ хуралдаанд нийт 13 үүрэг амлалтыг санал болгон хэлэлцсэн юм. Нэг сарын хугацаанд Ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнээрээ 4 удаа, дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр 4 удаа хуралдаж, цахимаар 3 удаагийн санал авч, орон даяар олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Нийт 20 төрийн байгууллага, 30 төрийн бус байгууллага санал ирүүлж, эдгээр саналыг ХБТМ-ын зөвлөмжийн дагуу хэлэлцэж, холбогдох асуудлыг тусгасан.

ҮҮАТ V-ийн эцсийн төслийг Монгол Улсын НЗТ-ийн Үндэсний зөвлөл 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр баталсан бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар албан ёсоор баталгаажуулсан. ҮҮАТ V дараах 9 үүрэг амлалтыг агуулж байна:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах;
2. Мэдээллийн ил тод байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар төрөөс мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаатай хангаж, төрийн ил тод байдлыг сайжруулах;
3. Иргэний нийгмийн орон зай, төлөвшил, эвлэлдэн нэгдэх эрхийг дэмжиж, хараат бусаар, бие даан, өөрийгөө удирдан явуулах боломжийг бүрдүүлсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
4. Ардчилсан ёсыг бэхжүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах;
5. Улсын төсөв, төсвийн хөрөнгө оруулалтад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх;
6. Нийгмийн бүх бүлэгт төрөөс үзүүлж буй үйлчилгээг оновчтой болгох;
7. Нээлттэй өгөгдөл;
8. Төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдийн сэтгэл ханамжаар тогтмол дүгнэж, оролцоог нэмэгдүүлэх;
9. Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлыг нэмэгдүүлэх.

ХБТМ-ын зөвлөмжийн ашиглалт				
Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний тойм: Монгол Улс 2023-2027 тайлан 2024 оны 8 дугаар сард нийтлэгдсэн. Тайланд дурдсан зөвлөмж нь 2027 оны Ерөнхийлөгчийн сонгууль хүртэл Монголын НЗТ-ийн Дэмжих нэгж болон Ажлын хэсэгт төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай хангалттай нөөц бололцоог бүрдүүлэх нь зайлшгүй шаардлагатайг онцолсон байна. Энэ төлөвлөгөө нь Монгол Улсын дөрвөн жилийн хугацаагтай анхны төлөвлөгөө тул ХБТМ үүрэг амлалтын үр нөлөөг сайжруулахын тулд төлөвлөгөөг шинэчлэх үйл явцыг санал болгож байна. Шинэчлэх явцад одоогийн үүрэг амлалтын зорилгын түвшинг нэмэгдүүлэх буюу шинэ үүрэг амлалтыг төлөвлөгөөнд нэмэхэд туслах болно.				
Үүрэг амлалтын үнэлгээ				
Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн Ахиц дэвшил сул Огт эхлээгүй эсвэл Ноцтой саатсан				
Үүрэг амлалт	Үнэлгээний дүн (Ногоон/Шар/Улаан)	Үнэлгээг нотлох баримт	Үнэлгээ хийсэн шалтгаан	Дараагийн алхам
Зорилт 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах				
1.1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх	Ахиц дэвшил сул	ЗГХЭГ: Монгол Улын сайд, ЗГХЭГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 04 дүгээр тушаалаар хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэг байгуулагдсан. Хуулийн тандан судалгаа хийгдсэн. Төсөл боловсруулах шатанд явж байна. АҮЭБЯ: Энэ хуулийн төслийн хэлэлцүүлгийг ХЗДХЯ дээр 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт төрийн захиргаа, компани болон төрийн бус байгууллагын төлөөлөл 60 гаруй төлөөлөл оролцож саналаа өгсөн байна. Хуулийг төслийг ХЗДХЯ-ны цахим хуудас https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da дээр байршуулж санал авч байна. Яамд, компани, иргэний нийгмийн байгууллагуудын саналыг авсан. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг АҮЭБ, БОУАӨ, Сангийн, ХЗДХ-ийн сайд нар 2025 оны 6 дугаар сард шинэчлэн баталж байна. АМГТГ: ХЗДХЯ, ОУИТБС-ийн ажлын албатай хамтран ХЗДХЯ-ны хурлын танхимд 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай анхдагч хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцож, хуулийн төсөлд 2 санал өгсөн.	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-Төслийн үзэл баримтлалыг шинэчлэх батлах -Засгийн газрын хуралдаанд танилцуулах -УИХ-д өргөн мэдүүлэх, хэлэлцүүлэх.

1.2.Ил тод байдлыг хангах чиглэлээр төрийн холбогдох байгууллага, төрийн, орон нутгийн, хувийн, холимог өмчит компаниудын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, өөрийн үйл ажиллагаанд хамаарах мэдээллийг тухай бүр нээлттэй өгөгдөл хэлбэрээр мэдээллийн санд байршуулж хэвшүүлэх; Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тайлангаар дамжуулан нийтэд ил тод болгодог мэдээллийг төрийн байгууллагууд өөрсдийн цахим хуудсаар дамжуулан шууд мэдээлдэг болох	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	БОУАӨЯ: Байгаль орчны мэдээллийн сан нь байгаль орчны өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, цуглуулах, дамжуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, баяжуулах, өөрчлөх, шинэчлэх, хамгаалах зэрэг үйл ажиллагааг хангах үндсэн 23 мэдээллийн сан, 54 мэдээллийн дэд санг нээлттэй ажиллуулж байна. Мөн хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээллийг яамны албан ёсны цахим хуудсанд ил тод, нээлттэй байдал хэсэгт байршуулан ажиллаж байна. ОҮИТБС-ын ажлын албанд уул уурхайн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн баталгааны дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийн мэдээллийг хүргүүлж, ажлын албанаас тайланг нэгтгэж, нээлттэй байршуулдаг. АҮЭБЯ: ОҮИТБС-ын цахим тайлагналын системийг 2023 онд Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр шинэчилсэн. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд болон төрийн холбогдох байгууллагуудын албан тушаалтныг 2024 болон 2025 онд сургалтад хамруулсан бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд болон төрийн холбогдох байгууллагууд 2023, 2024 оны ОҮИТБС-ын тайлангаа энэ системээр гаргасан байна. АМГТГ: Ил тод байдлыг хангах чиглэлээр төрийн байгууллагын өөрийн үйл ажиллагаанд хамаарах мэдээллийг тухай бүр нээлттэй өгөгдөл хэлбэрээр мэдээллийн санд байршуулж хэвшүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор баталсан Агентлагийн үйл ажиллагааны 25 төрлийн нээлттэй өгөгдлийг байгууллагын цахим хуудас www.mrpm.gov.mn-ны мэдээ мэдээлэл цэсэд болон https://opendata.gov.mn/-д тогтмол шинэчлэн нийтэлж байна. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлангийн цахим системийг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хялбар, нээлттэй хүргэх зорилгоор АМГТГ-ын цахим хуудасны нүүр хуудсанд https://ereports.eitimongolia.mn/ холбоосыг тогтмол байршуулан ажиллаж байна. Мөн ОҮИТБС-ын тайлангийн системийн талаар болон тус байгууллагатай холбогдох асуудлаар тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн АМГТГ-ын мэдээлэл лавлагааны тусгай дугаар 77771900-д ирсэн дуудлагад холбогдох лавлагаа, мэдээллийг өгч ажиллаж байна.	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-
---	---	--	---	----------

1.3.Ил тод байдлыг хэрэгжүүлэх ажиллагааны санхүүжилтийг төсөвт шийдвэрлэх үйл улсын тусгаж	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	СаЯ: АҮЭБ-ийн сайдын 2025 оны төсвийн багцад олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулахтай холбоотойгоор 493.1 сая төгрөг батлагдсан. АҮЭБЯ: 2025 оны улсын төсөвт үйл ажиллагааны санхүүжилтийг 491.1 сая төгрөгөөр батлагдсан. 2026 оны төсвийн төсөөлөлд 633,3 сая төгрөгөөр төлөвлөгдсөн байна.	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-
Зорилт 2.Мэдээллийн ил тод байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар төрөөс мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаатай хангаж, төрийн ил тод байдлыг сайжруулах				
2.1.Нээлттэй мэдээллийг “shilen.gov.mn” системд нийтлэх	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	ЦХИХХЯ: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд ЦХИХХ-ны сайдын 2024 оны А/46 дугаар тушаалаар Авлигатай тэмцэх “5Ш” ажиллагааны хүрээнд “Шил ажиллагаа”-ны хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар ханган, шаардлагатай мэдээ, мэдээллийг нэгтгэж, шилэн индексийн үнэлгээг зарлах үүрэг бүхий Штабыг шинэчлэн байгуулан ажиллаж байна. Тус штаб нь мэдээлэл хариуцагч байгууллага хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг ил тод байршуулсан эсэхэд Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ээр дамжуулан үнэлгээ өгч, холбогдох заавар, мэдээллээр ханган ажиллаж байна. Энэ хүрээнд төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын 40 агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тухай бүр албан бичиг хүргүүлэн, нийт 3,782 байгууллагын 4,014 албан хаагчдад системийн хандах эрхийг олгож, сургалтыг үе шаттай зохион байгуулан ажиллаж байна. Мөн нээлттэй мэдээллийг сурталчлан таниулах зорилгоор МҮОНТ, “Ийгл” телевизээр мэдээллийг хүргэн ажилласан. 2025 оны I улирлын байдлаар нийт 1,126 байгууллага мэдээллийн ил тод байдлын "Шилэн индекс"-ийн тайланг нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ээр дамжуулан илгээсэн ба төрийн захиргааны төв байгууллага 92.61% (ЗГХЭГ болон 11 яам), төрийн захиргааны байгууллага 79.61% (23 агентлаг), Нийслэлийн Засаг даргын Тамгын газар 55.59% (6 ЗДТГ), нутгийн захиргааны байгууллага 75,84% (14 аймаг)-тай үнэлэгдээд байна. Шилэн үнэлгээ-Яам 1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 97.73% 2. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам 95.75%	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-

		3. Хууль зүй, дотоод хэргийн яам 95.33% 4. Сангийн яам 94.94% 5. Эдийн засаг, хөгжлийн яам 94.84% 6. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам 94.31% 7. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 90.83% 8. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам 90.57% 9. Боловсролын яам 89.70% 10. Эрчим хүчний яам 89.48% 11. Батлан хамгаалах яам 89.22% 12. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам 88.67% Нийт 92.61% Шилэн үнэлгээ-Агентлаг 1. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар 96.4% 2. Оюуны өмчийн газар 81.38% 3. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар 57.7% 4. Иргэний нисэхийн ерөнхий газар 81.21% 5. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар 88.83% 6. Монополын эсрэг газар 91.21% 7. Стандарт, хэмжил зүйн газар 90.02% 8. Ашигт малтмал, газрын тосны газар 66.5% 9. Усны газар 77.6% 10. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар 55.68% 11. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 57.62% 12. Нийгмийн даатгалын ерөнхий газар 94.25% 13. Биеийн тамир, спортын улсын хороо 63.39% 14. Гаалийн ерөнхий газар 94.76% 15. Цагдаагийн ерөнхий газар 64.65% 16. Шүүх шинжилгээний ерөнхий газар 99.84% 17. Соёл, урлагийн газар 56.47% 18. Архивын ерөнхий газар 98.23% 19. Татварын ерөнхий газар 60.13% 20. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 82.08% 21. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 81.27% 22. Гадаадын иргэн, харьяатын газар 99.83%		
--	--	---	--	--

		23. Хил хамгаалах ерөнхий газар 61.36 Нийт 79.61% Шилэн үнэлгээ - Дүүрэг 1. Налайх дүүрэг 65% 2. Багахангай дүүрэг 68% 3. Сүхбаатар дүүрэг 57% 4. Чингэлтэй дүүрэг 51% 5. Баянзүрх дүүрэг 62% Нийт 60.6% Шилэн үнэлгээ - АЗДТГ 1. Говь-Алтай аймгийн засаг даргын тамгын газар 68.29% 2. Архангай аймгийн Засаг даргын тамгын газар 99.73% 3. Өмнөговь аймгийн ЗДТГ 71.71% 4. Дорноговь аймгийн ЗДТГ 91.54% 5. Говьсүмбэр аймгийн ЗДТГ 98.26% 6. Булган аймгийн ЗДТГ 71.73% 7. Төв аймгийн ЗДТГ 74.84% 8. Дундговь аймгийн ЗДТГ 82.75% 9. Дорнод аймгийн ЗДТГ 62.18% 10. Сэлэнгэ аймгийн ЗДТГ 100.00% 11. Орхон аймгийн ЗДТГ 83.90% 12. Хөвсгөл аймгийн ЗДТГ 91.23% 13. Сүхбаатар аймгийн ЗДТГ 70.40% 14. Өвөрхангай аймгийн ЗДТГ 60.94% 15. Хэнтий аймгийн ЗДТГ 55.19% Нийт 78.84% АМГТГ: АМГТГ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу Агентлагийн үйл ажиллагаа, хуулиар хориглоогүй 100 гаруй төрлийн мэдээллийг олон нийт, үйлчлүүлэгчдэд ил тод, нээлттэй байлгаж, мэдээлэл авах адил тэгш боломжоор хангах хүрээнд байгууллагын цахим хуудас www.mnram.gov.mn дээр болон тус цахим хуудасны Ил тод байдал цэсэд https://shilendans.gov.mn/-г холбож Шилэн дансны тухай болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай хуульд тус тус заасан байгууллагын 27 төрлийн нээлттэй мэдээлэл, Мэдээ мэдээлэл цэсэд https://opendata.gov.mn/ Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор баталсан Агентлагийн үйл		
--	--	--	--	--

		ажиллагааны 25 төрлийн нээлттэй өгөгдлийг тогтмол шинэчлэн нийтэлж байна. Мөн нээлттэй мэдээллийг хүртээмжтэй хүргэх үүднээс байгууллагын болон хэлтэс нэгжийн мэдээллийн самбарт тогтмол шинэчлэн байршуулахаас гадна олон нийтийн сошиал орчинд нийтэлж мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна. Нээлттэй мэдээлэл нийтэлсэн тайлангаа улирал тутам https://shilen.gov.mn/ дээр тайлагнаж үнэлүүлэн ажиллаж байна.		
2.2.Эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалт, хяналтын цахим тогтолцоог сайжруулах	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	ЭЭХХЗГ: 1.ЭЭХХЗГ-ын үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулах тухай агентлагийн даргын 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А/59 дүгээр тушаал батлагдаж, дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд: -Хилээр орж ирж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг гаалийн мэдээллээс иргэдийн гарт очих хүртэлх мэдээлэл солилцох, эмийн үнэ, чанар, аюулгүй байдлын хяналтыг сайжруулахаар гаалийн автоматжуулсан мэдээллийн системтэй 40 төрлийн мэдээлэл солилцож байна. Мэдээлэл солилцож байгаа сервист импортын мэдүүлгийг гаалийн системд 1 дуудагдах дахин дуудагдахгүй байх тохиргоо хийж бүрэн цахимжуулсан. -Эмийн бүртгэлийн Лайсмед программаас Төрийн мэдээлэл солилцооны Хур системд импортлогдсон эмийн цувралын дугаарыг бар кодоор лавлах сервис нээлттэй байршуулсан. Ингэснээр тус цувралын дугаарыг ашиглан эмийн сангууд И-баримт дээр хэвлэх нөхцөл бүрдэж, иргэд эмийн сангаас худалдан авсан эмийн цувралын дугаарыг И-баримтын цувралын дугаартай ижил байгааг харж, хууль бус болон хуурамч эмийн эргэлтийг илрүүлэх, таслан зогсоох нөхцөл бүрдсэн. -Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, үнийн өсөлтөд хяналтын тогтолцоо бүрдүүлэхээр Цахим төлбөрийн баримтын систем (POS API 2.0)-ийг шинэчилж, эмийн цувралын дугаар, үнэ, жижиглэнгийн үнийн мэдээллийг хянах, эмийн зах зээлийн дараах чанар аюулгүй байдлын хяналтыг цувралын дугаараар мөшгөх тогтолцоог бүрдүүлж, Цахим төлбөрийн баримтын систем “POS API 3.0”-д цувралын дугаараар бүртгэн И-баримтын загварт цувралын дугаар хэвлэх боломжийг бий болгож “Цахим мэдээллийн нэгдсэн сан” бий болгохоор ажиллаж байна. -Дийг Ай Ти ХХК-тай 2024 онд “ЭЭХХЗГ-ын суурь системийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах” ЭЭХХЗГ/03/28 дугаар ажил гүйцэтгэх гэрээний дагуу эм, эмнэлгийн	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-

		хэрэгслийн хяналт, зохицуулалтын нэгдсэн цахим систем /Digital.mmra.gov.mn/-ийн хөгжүүлэлт хийж Лабораторын удирдлага, Импортын мэдүүлгийн удирдлага, Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэлийн удирдлагын модулийн хөгжүүлэлт дуусч Эмийн бүртгэлийн мэдээний сан Лайсмед программ, Эм шинжлэх лабораторийн ЛИМС программын өгөгдлийн сан хөрвүүлэх ажил хийгдэж байна. 2.И-Монгол академи УТҮГ-т цахимаар хүлээн авч байгаа үйлчилгээний зохицуулалтыг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээ хэрэгжүүлсэн. Үүнд: -Жоргүй олгох эмийн зар сурталчилгааны агуулгыг дамжуулан word файлаар хүлээн авах хүсэлт -Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний зар сурталчилгааны зөвшөөрлийг эмнэлгийн хэрэгслийн зар сурталчилгааны зөвшөөрөл болгох хүсэлт -Үндэсний үйлдвэрийн эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, импортын эмийн сунгалт, хасалт, өөрчлөлтийн бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах хүсэлт -Вакцин, биобэлдмэлийн бүртгэлийн баримт бичгийг цахимаар хүлээн авах хүсэлт -Бүртгэлийн шинжээч нарыг санамсаргүй аргаар сонгох талаар хөгжүүлэлтийг хийлгэх хүсэлтийг тус тус хүргүүлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлсэн. Бүртгэлийн шинжээч нарыг санамсаргүй аргаар сонгох үйл ажиллагааг шинжээчийн сонгон шалгаруулалтыг хийсний дараа хийх боломжтой болсон. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл-78, видео контент-12, рийл-2, эмийн аюулгүй байдлын талаарх сэрэмжлүүлэг мэдээлэл-4, эмийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой-8, тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбоотой тушаал-6 байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна.		
2.3.Олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, нээлттэй өгөгдлийг хүртээмжтэй түгээх	Ахиц дэвшил сул	АҮЭБЯ: ОУИТБС-ын цахим тайлагналын системийг хөгжүүлж, мэдээллийн үндсэн сан болгох чиглэлийг баримталж байна. Мөн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслөөр ил тод болох мэдээллийг нээлттэй өгөгдөл байхаар томьёолж өгсөн байна. АМГТГ: Монгол улсын Засгийн газрын 2017 оны “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 263 дугаар тогтоол болон УУХҮ-ийн сайдын 2022 оны 5 дугаар сарын 31-	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль батлагдахад мэдээллийг нээлттэй өгөгдөл байхаар бэлтгэл ажил хангах.

		ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан ОУИТБС-ийн 4 дүгээр маягтын дагуу ашигт малтмал, газрын тосны хайгуул, олборлолт эрхлэгч аж ахуйн нэгжээс жилийн улсын төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хураамж, хандив, тусламжийн орлогын тайланг Монголын Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн Ажлын албанд жил бүр хүргүүлж байна. Уг мэдээллийг Олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн нэгдсэн санд хадгалж, холбогдох байгууллагыг дээрх мэдээллээр ханган ажиллаж байна.		
2.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нарын ТББ-уудтай хийсэн гэрээ, санхүүжилт, үйл ажиллагааны үр дүнгийн мэдээллийг ил тод болгох	Огт эхлээгүй эсвэл Ноцтой саатсан	АҮЭБЯ: Мэдээлэл ирээгүй.	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-АҮЭБЯ-аас мэдээлэл ирүүлэх. -Үйл ажиллагааны үр дүнгийн мэдээллийг ил тод болгох.
Зорилт 3.Иргэний нийгмийн орон зай, төлөвшил, эвлэлдэн нэгдэх эрхийг дэмжиж, хараат бусаар, бие даан, өөрийгөө удирдан явуулах боломжийг бүрдүүлсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох				
3.1.Иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангах болон иргэний нийгмийн төрөөс хараат бус, санхүүгийн тогтвортой ажиллах хууль зүйн баталгааг бүрдүүлэх, иргэний орон зайд хийдэл, бэрхшээл учруулж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох	Ахиц дэвшил сул	ХЗДХЯ: Холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн баталгааг хангах, иргэний нийгмийн хөгжлийг дэмжих, холбооны эрх зүйн байдал, үйл ажиллагаатай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахаар тусгасан. Тухайлбал: Иргэд сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхийн үндсэн дээр бүртгэлтэй болон бүртгэлгүй холбоо байгуулах эрх зүйн үндсийг тодорхойлж, үйл ажиллагаагаа төрөөс хараат бусаар, өөрийгөө удирдан хууль тогтоомжийн хүрээнд явуулах, эвлэлдэн нэгдэх эрхийг зөвхөн сайн дурын үндсэн дээр явуулах үндсэн зарчмыг тодотгон эвлэлдэн нэгдэх, холбоо байгуулах, гишүүнээр элсэх, гишүүнчлэлээс татгалзах эрхийг хязгаарлахыг хориглох, түүнчлэн ялгаварлан гадуурхахыг хориглосон. Холбоо, сан нь хуулийн этгээд болохын хувьд Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх одоогийн эрх зүйн зохицуулалтыг хэвээр хадгалсан бөгөөд харин бүртгэлийг хялбар байдлаар явуулах, цахимаар бүртгүүлэх, холбооны санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх, төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх, нийтэд тустай үйл ажиллагааг явуулах зэрэг зохицуулалтыг тус тус тусгасан. Мөн түүнчлэн дээрх хуулийн төсөлд санхүүжилт, санхүүжилтийн эх үүсвэрийг нээлттэй, ил тод, олон улсын стандартад нийцүүлэх хүрээнд холбоо, сан нь хуулиар хориглоогүй	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-Төрийн бус байгууллагын тухай хуулийн төсөл, төслийн үзэл баримтлалыг боловсруулж, Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг ЭЗХЯ-аар дүгнэлт гаргуулах. -Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулахаар холбогдох судалгааг хийх.

		санхүүжилтийн бүхий л эх үүсвэртэй байж болох бөгөөд санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалт нь нээлттэй, ил тод байх хүрээнд санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа өөрийн цахим хуудсанд нийтэд ил тод мэдээлэхээс гадна Иргэний нийгмийг дэмжих зөвлөлд, төрийн чиг үүргийг гүйцэтгэсэн, эсхүл төртэй гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулсан бол тайлангаа тухайн төрийн байгууллагад хүргүүлж, нийтэд танилцуулахаар тус тус тусгаж, санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бий болгосноор эвлэлдэн нэгдэх эрхийг холбооны хэлбэрээр хэрэгжүүлэхэд ач холбогдолтой болсон. Төрийн бус байгууллагатай “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг гаргасны дараагаар Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэхээр тохирсонтой холбогдуулан Төрийн бус байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, төслийн үзэл баримтлал, “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл, төслийн үзэл баримтлалыг боловсруулан хууль, УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг ЭЗХЯ-д дүгнэлт гаргуулахаар хүргүүлсэн. УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4-т “Өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцно.” гэж заасны дагуу Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг шинэ Засгийн газар байгуулагдсантай холбоотойгоор буцаасанд тооцсон тул хуулийн төслүүдийг шинэчлэн боловсруулахаар холбогдох судалгааг хийж, төслийг тус яамнаас дахин боловсруулж байна. Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 59-д Холбооны эрх зүйн байдлын тухай (шинэчилсэн найруулга) хуулийн төсөл, 60-д Сангийн эрх зүйн байдлын тухай (анхдагч хууль) хуулийн төслийг 2026 онд УИХ-д өргөн мэдүүлэхээр заасан.		-Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 59, 60-н бэлтгэл ажлыг хангах.
3.2.Иргэний нийгмийн олон улсын суурь зарчим, үнэт зүйл, хариуцлага, нийтэд тустай үйл ажиллагааг төрөөс хэрхэн дэмжих зэрэг асуудлыг	Ахиц дэвшил сул	ЭЗДХЯ: 2024 оны 8 дугаар сарын 27-ний өдрийн УИХ-ын 21 дугаар тогтоолоор Монгол Улсын дунд хугацааны бодлогын баримт бичиг “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.3.-т зааснаар Иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-"Хүний эрхийг хангах үндэсний II хөтөлбөр"-ийг боловсруулахад иргэний нийгмийн олон улсын суурь

Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдэд тусгах		түншлэл, хамтын ажиллагаа гэх зорилт тавин Иргэний нийгмийн олон улсын суурь зарчим, үнэт зүйл, хариуцлага, нийтэд тустай үйл ажиллагааг төрөөс дэмжих асуудлыг тусгаж Засаглалын үзүүлэлтийг сайжруулах зорилго дэвшүүлэн ажиллаж байна. Мөн Монгол Улсын богино хугацааны бодлогын баримт бичиг болох Монгол Улсын хөгжлийн 2025 болон 2026 төлөвлөгөөнд “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого”-ийг Тэргүүлэх чиглэл болгон тусгасан. Монгол Улсын Шадар сайд бөгөөд ЭЗХ-ийн сайдын 2023 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн А/25 дугаар тушаалаар “Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах аргачлал”-ыг баталсан. Тус аргачлалын дагуу ЭЗХЯ-аас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт заасан “Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр”, “Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”, “Байгаль орчны зорилтот хөтөлбөр”, “Засаглалын зорилтот хөтөлбөр”, “Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”, “Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр”, “Шинжлэх ухаан, технологийн зорилтот хөтөлбөр”-ийн төслүүдийг боловсруулан ажиллаж байна. Иргэний нийгмийн олон улсын суурь зарчим, үнэт зүйл, хариуцлагад суурилсан нээлттэй, хариуцлагатай засаглалын асуудлыг “Засаглалын зорилтот хөтөлбөрийн төсөл”-д тусган ажиллаж байна. Мөн УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1.2-т “Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний II хөтөлбөр”-ийг батлуулж, хэрэгжүүлэх”-ээр заасны дагуу УИХ-ын 2024 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн 93 дугаар захирамжаар “Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний II хөтөлбөрийг батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан бөгөөд түүнийг УИХ-ын гишүүн Х.Баасанжаргал ахалж, гишүүдээр нэр бүхий 12 УИХ-ын гишүүн ажиллаж байна. Тус үйл ажиллагааг хангах зорилгоор ХЗДХ-ийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/130 дугаар тушаалаар “Хүний эрхийг хангах үндэсний II хөтөлбөр”-ийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсгээс хөтөлбөрийн төслийг боловсруулаад байна.		зарчим, үнэт зүйл, хариуцлага, нийтэд тустай үйл ажиллагааны талаар тусгахад анхаарах. “Монгол Улсыг 2026-2031 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д Иргэний нийгмийн олон улсын суурь зарчим, үнэт зүйл, хариуцлага, нийтэд тустай үйл ажиллагааг төрөөс хэрхэн дэмжих зэрэг асуудлыг Засаглалын тэргүүлэх чиглэлд тусгах.
---	--	--	--	---

		Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах цаглаврын дагуу “Монгол Улсыг 2026-2031 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д Иргэний нийгмийн олон улсын суурь зарчим, үнэт зүйл, хариуцлага, нийтэд тустай үйл ажиллагааг төрөөс хэрхэн дэмжих зэрэг асуудлыг Засаглалын тэргүүлэх чиглэлд тусгахаар ажиллаж байна.		
3.3.Төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагын санхүү, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, тайлагнах, дүгнэх журмыг батлах	Огт эхлээгүй эсвэл Ноцтой саатсан	ХЗДХЯ: Энэхүү журмыг батлах эрх зүйн үндэслэлийг судлан үзэхэд ХЗДХ-ийн сайдад /Хууль, УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ЗГ-ын тогтоол/ эрх олгосон заалт байхгүй байна. Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд төрийн бус байгууллагын санхүү, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, тайлагнах, дүгнэх зохицуулалтыг тусгасан. УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4-т “Өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцно.” гэж заасны дагуу Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг шинэ Засгийн газар байгуулагдсантай холбоотойгоор буцаасанд тооцсон. Холбоо, сангийн төрөл, ангилал, дотоод зохион байгуулалт, удирдлага, төлөөлөл, үүсгэн байгуулагчийг тодорхой болгох, сангийн бүртгэл, хяналт, тайлагналт, ил тод байдал, татан буугдах нөхцөл, журмыг боловсронгуй болгох, төрөөс санд үзүүлэх дэмжлэг, төрийн чиг үүргийг гүйцэтгүүлэхтэй холбоотой зохицуулалтыг бий болгох хүрээнд Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулахаар холбогдох судалгааг хийж, төслийг тус яамнаас боловсруулж байна. Уг хуулийн төсөл батлагдсанаар тус журмыг хуулиар хэрэгжүүлэх боломжтой болно.	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэх явцад тус зорилгыг дахин хэлэлцэх. -Шинэчлэх журмыг хуулиар хэрэгжүүлэх боломжийг бий болгох.
3.4.Төсвөөс санхүүжилт авсан төрийн бус байгууллагын гэрээ, санхүүжилт, ажлын үр	Ахиц дэвшил сул	СаЯ: “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг шинэчлэн боловсруулахаар СЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн А/49 тоот	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	Журмыг шинэчлэн боловсруулахад төсвөөс санхүүжилт

дүнгийн мэдээллийг ил тод болгох		тушаалаар ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу журмын төслийг шинэчлэн, холбогдох заалтыг тусгахаар ажиллаж байна.		авсан төрийн бус байгууллагын гэрээ, санхүүжилт, ажлын үр дүнгийн мэдээллийг ил тод болгох заалт тусгах.
Зорилт 4.Ардчилсан ёсыг бэхжүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах				
4.1.Төрийн нууцын жагсаалтыг хуулиар батлах зохицуулалтыг Төрийн болон албаны нууцын тухай хуульд оруулж, төрийн болон албаны нууцын жагсаалтыг мэдээллийн ил тод байдлын зорилгод нийцүүлэх	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	ХЗДХЯ: Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус яамнаас боловсруулж, 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн УИХ-д өргөн мэдүүлсэн. УИХ-ын 2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн. Хүний эрхийг хангахтай холбоотой багц хуулийн төслийн зорилго нь үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэн боловсруулагдсан ба Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай уялдуулан боловсронгуй болгох зорилгоор Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд албаны нууцын тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох, албаны нууцын хүрээ хязгаарыг багасгах, тухайн байгууллагын даргын шийдвэрээр албаны нууцад хамааруулж байгаа зохицуулалтыг эргэн харах, иргэдийн мэдээлэл авах эрхийг хязгаарлаж байгааг арилгах хуулийн зохицуулалтыг тусгасан.	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлах.
4.2.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг эцэслэн боловсруулж, өргөн мэдүүлэх	Ахиц дэвшил сул	ХЗДХЯ: Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг тус яамнаас боловсруулж, 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд УИХ-ын 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгэхээр Төрийн байгуулалтын болон Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-Хэвлэл мэдээллийн байгууллагуудын саналыг тусгах. -Хуулийн төслийг өргөн мэдүүлэх.
4.3.Сэтгүүлчээс эх сурвалжаа нууцлах баталгаатай холбогдсон зохицуулалтыг Шүгэл үлээгчийг хамгаалах	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	ХЗДХЯ: УИХ-д өргөн мэдүүлсэн Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1-т “хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхтэй” гэж, мөн хуулийг даган боловсруулсан	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	

тухай болон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд тусгах		Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.7 дахь заалтад “хуульд өөрөөр заагаагүй бол хэвлэл мэдээллийн байгууллагын редакцияар дамжсан сэтгүүл зүйн үйл ажиллагааны хүрээнд мэдээ, мэдээлэл бэлтгэх, түгээх ажилд мэргэжлийн үүргээр оролцсон этгээд”-ээс гэрчийн мэдүүлэг авахгүй байхаар тусгасан. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг тус яамнаас боловсруулж байна. Тус хуулийн төсөлд шүгэл үлээгч эрх бүхий байгууллагад мэдээлэл өгсөн асуудлаар олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагад хандаж болох зохицуулалтыг тусгаж, олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллага нь шүгэл үлээсэн асуудлыг мэдээлсэн эх сурвалжаа нууцлах эрхтэй байхаар зохицуулсан.		
4.4.Хэвлэл мэдээллийн салбарын ёс зүйн асуудлыг боловсронгуй болгох	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	ХЗДХЯ: УИХ-д өргөн мэдүүлсэн Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтад “хэвлэл мэдээллийн салбарт өөрийн зохицуулалтын тогтолцоог хэрэгжүүлэх байгууллага ажиллана. Байгууллага нь бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаагаа бие даан шийдвэрлэнэ” гэж, мөн 14.2 дахь заалтад “14.1-д заасан байгууллага нь хэвлэл мэдээллийн салбарын мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг батална” гэж тус тус тусгасан.	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	Хэвлэл мэдээллийн байгууллагуудын саналыг тусгах.
4.5.Иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, жагсах цуглах зэрэг хүний эрхийн олон улсын механизмаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	ХЗДХЯ: Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг тус яамнаас эцэслэн боловсруулж, Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. УИХ-ын 2025 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалыг хүрээнд хэлэлцэх эсэхийг дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд: -Жагсаал, цуглаан санаачлан зохион байгуулах этгээдэд хязгаарлалт тавихгүй байх буюу хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага санаачлах, зохион байгуулах, оролцох эрхтэй байх; -Хүчин төгөлдөр хуульд жагсаал, цуглаан зохион байгуулах, санаачлах асуудал нь тодорхой хүрээ хязгаартай, тухайлбал улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар гэж тусгайлан заасныг өөрчилж, ямар ч асуудлаар жагсаал, цуглаан хийж болохоор нээлттэй байх;	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлэх.

		-Аяндаа бий болсон жагсаалыг мэдэгдэл хүргүүлсэн жагсаалын адил хүлээн зөвшөөрөх, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, хэв журам хамгаалах; -Бүртгүүлэх нэртэй боловч зөвшөөрөл авдаг тогтолцоог халж хуулиар хориглосноос бусад газар зөвхөн мэдэгдэл хүргүүлснээр зохион байгуулах боломж бүрдүүлэх; -Мэдэгдэл хүлээн авах, хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах эрх бүхий этгээд нь Засаг дарга буюу улс төрийн албан тушаалтан байгааг өөрчлөх; -Нийгмийн дэг журмыг хангах, үндэсний аюулгүй байдал, бусад этгээдийн аюулгүй байдлыг хангах шаардлагаар зөвхөн хуулиар /байршил, зорилго, агуулга, субъект, цаг хугацаа/ хориглолт, хязгаарлалтыг тогтоохыг хүлээн зөвшөөрнө. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиас гадна бусад хуулиар зохицуулсан хориглолт хязгаарлалтыг энэ хуулийн төсөлд нэгтгэн тусгаж зайлшгүйгээс бусад хориглолт, хязгаарлалтыг аль болох багасгах, жагсаал, цуглаан хийх эрхийг хориглосон, хязгаарласан агуулгатай захиргааны акт баталж мөрдүүлэхийг хориглох; -Зөвхөн хуульд заасан үндэслэлээр, тараах үндэслэл гарцаагүй бий болсон нь тогтоогдсон гэж үзсэн тохиолдолд албадан тараах, ингэхдээ тус ажиллагааг баримтжуулах, урьдчилан сануулах, оролцогчдын хувийн байдалд тохирсон арга хэмжээ авах, аль болох хамгийн бага хүч хэрэглэх аргыг сонгох, тус ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэл өгдөг байх; -Жагсаал цуглааныг сурвалжлах, мэдээлэх эрхэд хязгаарлалт тавихгүй байх, жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцох эрхийг зөрчиж байгаа гэж үзсэн тохиолдолд эрх бүхий этгээдэд гомдол гаргах эрх нээлттэй байх. -Цагдаагийн байгууллага жагсаалд оролцогчийн болон бусад этгээдийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журмыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж хүргүүлэх, эрх, үүргийг сануулах, жагсагчидтай ойр байж хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх, цагдаагийн албан хаагч ёс зүй, хүний эрхийн болон хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор сургалтад хамрагддаг байх, процесс ажиллагааг боловсронгуй болгохоор Цагдаагийн албаны тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулах зэрэг хүний эрхийн олон улсын механизмаас өгсөн зөвлөмжтэй холбогдох асуудлыг тусгасан. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг тус яамнаас эцэслэн боловсруулж, Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр УИХ-		
--	--	---	--	--

		д өргөн мэдүүлсэн бөгөөд УИХ-ын 2025 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг дэмжиж, анхны хэлэлцүүлэгт Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.		
4.6.Орон нутагт иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, түүний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	ХЗДХЯ: ХЗДХЯ-ны эрхлэх асуудлын хүрээний чиг үүрэгт орон нутагт иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, түүний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх эрх зүйн үндэслэлгүй байна. Харин Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний хуулийн төслийг боловсруулах хүрээнд хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийсэн бөгөөд судалгаагаар “Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т заасан эрх чөлөөний зарчмын дагуу аяндаа үүссэн эсхүл бусад аливаа хэлбэрийн тайван жагсаал, цуглааныг хүлээн зөвшөөрөх, тараахгүй, шийтгэхгүй байх, цуглах эрх чөлөөг аль болох эдлүүлэх хэрэгтэй байна” гэсэн дүн гарсны дагуу холбогдох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-
4.7. Харилцаа холбооны сүлжээнд иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх нөхцлийг хязгаарлахыг хориглосон зохицуулалтыг харилцаа холбооны тухай хуулийн төсөлд тусгах	Ахиц дэвшил сул	ЦХИХХЯ: Иргэний үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх, мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах талаарх Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенц, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан эрхийг бэхжүүлэх хүрээнд харилцаа холбооны сүлжээнд хүний үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, олон нийтийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн хязгаарлалт тогтоохыг хориглох талаар Харилцаа холбооны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг “27.3.Харилцаа холбооны сүлжээнд хүний үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, олон нийтийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн хязгаарлалт тогтоохыг хориглоно.” гэж нэмэлт оруулах хуулийн төслийг Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг баримтлан ХЗДХ-ийн сайдтай хуулийн төслийн үзэл баримтлалыг хамтран батлахаар хүргүүлсэн. ХЗДХ-ийн сайдаас хуулийн төслийг “27.3.Хуульд зааснаас бусад үндэслэлээр харилцаа холбооны сүлжээнд хүний үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, олон нийтийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн хязгаарлалт тогтоохыг хориглоно.” гэж найруулгыг өөрчлөн 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр үзэл баримтлалын төслийг батлан ирүүлсэн.	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	Харилцаа холбооны тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх.

		Мөн хуулийн төсөлд санал авахаар хэвлэл мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 12 байгууллагад 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 02/2512 дугаартай албан бичгийг хүргүүлж, санал авах нээлттэй хэлэлцүүлгийг салбарын үйлчилгээ эрхлэгчид болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг оролцуулан 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Хэвлэл мэдээллийн зөвлөл, Монголын сайтын холбоо, Монголын фм, радиогийн холбоо, Ондо ХХК, Скайтел ХХК, Датаком ХХК нарын төлөөлөл саналаа илэрхийлсэн. Түүнчлэн ХЭҮК-оос 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн ТГ-01/1572 дугаартай албан бичгээр “хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт нэмэлт оруулах саналыг дэмжсэн” талаар санал ирүүлсэн бол Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 01/347 дугаартай албан бичгээр “энэхүү заалт нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.1.3 дахь заалтад “...харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах...” гэж заасантай зөрчилдөж байх тул хууль батлагдсан ч хэрэгжих боломжгүй байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “Харилцаа холбооны сүлжээнд хүний үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, олон нийтийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн хязгаарлалт энэ заалтад хамаарахгүй.” гэсэн агуулгатай нэмэлтийг хамтатган оруулах нь зүйтэй.” талаар тус тус саналаа илэрхийлсэн. ХЗДХЯ-аас хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг батлахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах саналыг дэмжээгүй тул оролцогчдоос ирүүлсэн саналыг тусгах боломжгүй байна.		
Зорилт 5.Улсын төсөв, төсвийн хөрөнгө оруулалтад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх				
Зорилт 5.1.Төсвийн ил тод байдлыг дээшлүүлэх				
5.1.1.Орон нутгийн төсвийн төлөвлөлтийн ил тод байдлыг хангахтай холбогдсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	СаЯ: Монгол Улсын төсвийн мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй, энгийн ойлгомжтой хүргэх зорилгоор Иргэдийн төсөв товхимлыг жил бүр цахим болон хэвлэмэл хэлбэрээр олон нийтэд түгээдэг. Үүнд: Тухайн жилийн Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Орон нутгийн төсөв болон бусад төсвийн мэдээллийг хамруулдаг. Мөн Орон нутгийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээг сар бүр СЯ-ны веб хуудас, Шилэн данс, Иргэдийн төсөв зэрэг нээлттэй өгөгдлийн системд байршуулан Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-

		Төсвийн ил тод байдлын хэрэгжилтийг тус тус ханган ажиллаж байна.		
5.1.2.Улсын болон орон нутгийн тухайн оны төсвийн төслийн танилцуулга болон түүнтэй холбоотой хавсралтуудыг нээлттэй өгөгдлийн стандартад нийцүүлэн ил тод, нээлттэй болгохтой холбогдсон зохицуулалтыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д тусгах	Ахиц дэвшил сул	СаЯ: “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг шинэчлэн боловсруулахаар СЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн А/49 тоот тушаалаар ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу журмын төслийг шинэчлэн, холбогдох заалтыг тусгахаар ажиллаж байна.	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	"Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ыг шинэчлэн боловсруулж батлах.
5.1.3.Тусгай сангийн төсвийг зарцуулах сонгон шалгаруулалт, санхүүжилт, төрийн өмчит компанийн 5 сая төгрөгөөс дээш худалдан авалттай холбогдох шийдвэр болон төрийн өмчийг актлах, устгах шийдвэрийг ил тод болгох зохицуулалтыг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д тусгах	Ахиц дэвшил сул	СаЯ: “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 1.2-т заасны дагуу байгууллагууд журамд заасан хугацааны дагуу шилэн дансны цахим хуудсанд мэдээллээ байршуулсан байна. “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын шинэчлэн боловсруулахаар СЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн А/49 тоот тушаалаар ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Тус журмын заалтад төрийн өмчийг актлах, устгах шийдвэрийг ил тод болгох зохицуулалтыг судлан, журамд тусгахаар ажиллаж байна.	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг шинэчлэн боловсруулж батлах. -Актлах шалтгаан, шийдвэр гаргах процесс, дуудлага худалдааг зохион байгуулсан байдал зэргийг тодорхой тусгах.
5.1.4.Тухайн жилийн төсвийн төсөлд тусгасан	Ахиц дэвшил сул	СаЯ:	Үндэсний зөвлөлөөс өгсөн	Төсвийн төсөлд тусгасан шинээр

шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэнтэй холбоотой мэдээллийг ил болгох		УИХ-ын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 01 дүгээр тогтоолоор чиглэл өгсний дагуу Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлаар харуулах зорилгоор СЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/53 дугаар тушаалаар холбогдох ажлын хэсгийг байгуулаад байна. Ажлын хэсэг хуралдаж, одоо ашиглаж байгаа publicinvestment.gov.mn /ПИМИС/ цахим системээс мэдээллийг шууд татан авч, олон нийтэд хүргэдэг байхаар системийн холболт, хөгжүүлэлтийг хийж эхлээд байна. Ингэснээр publicinvestment.gov.mn /ПИМИС/ болон iltod.gov.mn цахим хуудас дээрх шаардлагатай мэдээллийг бодит байдлаар олон нийтэд ил тод, хүртээмжтэй хүргэх боломж бий болно. Мөн төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг бүхэлд нь цахимд шилжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, ил тод нээлттэй байдлыг сайжруулах арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд СЯ Азийн Хөгжлийн Банкны дэмжлэгтэйгээр Монгол Улсын Олон Нийтийн Хөрөнгө Оруулалтын Менежментийн Мэдээллийн Системийн дараагийн үе болох PIMIS 4.0-ийг ашиглалтад оруулаад байна. Том өгөгдөл болон AI-р цэнэглэгдсэн PIMIS 4.0 нь олон нийтийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтыг нэг ухаалаг, дижитал платформд авчирч, үр ашгийг нэмэгдүүлэх, гарын авлагын ажлыг багасгах, ил тод байдлыг нэмэгдүүлэх юм. Энэ бол Монгол Улсад бүрэн цахим, датанд суурилсан олон нийтийн хөрөнгө оруулалтын менежментийг хийх томоохон алхам юм.	чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүдийн ач холбогдлоор эрэмбэлсэн болон төсвийн тодотголоор хасагдсан, нэмэгдсэн болон төсвийн дүнд өөрчлөлт оруулсан мэдээллийг ил тод болгох.
5.1.5.Төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын хасагдсан, нэмэгдсэн болон төсвийн дүнд оруулсан өөрчлөлттэй холбоотой мэдээллийг хавсралтаар гаргадаг болох	Ахиц дэвшил сул	СаЯ: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн жагсаалтад Төсвийн тодотголоор оруулсан холбогдох өөрчлөлт, тухайлбал нэмэгдсэн болон хасагдсан төсөл арга хэмжээ, түүнчлэн өөрчилсөн санхүүжилтийн дүн зэргийг харах, мөн төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, гадаад зээл, тусламжийн санхүүжилт, хэрэгжилтийн явцыг нийтэд ил тод, нээлттэй, ойлгомжтой байдлаар харуулах, хөгжүүлэлтийг хийх ажлын хэсгийг СЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/53 дугаар тушаалаар байгуулаад байна.	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	Төсвийн төсөлд тусгасан шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүдийн ач холбогдлоор эрэмбэлсэн болон төсвийн тодотголоор хасагдсан,

				нэмэгдсэн болон төсвийн дүнд өөрчлөлт оруулсан мэдээллийг ил тод болгох.
5.1.6.Төсвийн хэрэгжилт, ил тод байдлын систем хоорондын уялдаа, талуудын оролцоог тэгш хангаж санал солилцох, судалгаан дээр тулгуурлан хөгжүүлэх зорилгоор shilendans.gov.mn сайтыг шинэчлэх	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	СаЯ: СЯ-аас улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг СЯ-ны төсөв, санхүүгийн систем болон бусад томоохон систем, мэдээллийн сантай шууд холбосон. Ингэснээр мэдээлэл оруулах гар ажиллагааг хөнгөвчлөн, олон улсын нээлттэй өгөгдлийн стандартын дагуу мэдээлэл хайх, татаж авах, дахин ашиглах боломжийг бий болгон шинэчлэн нэвтрүүлсэн.Шинэчлэгдсэн шилэн дансны систем нь дараах системтэй холбогдон мэдээлэл солилцох боломжтой: Үүнд: 1. И-хуулга; 2. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем; 3. Эрхийн бүртгэлийн систем; 4. Орон нутгийн хөгжлийн сангийн систем; 5. Хөрөнгө оруулалтын систем, Аж ахуйн нэгж; 6. Төсөвт байгууллагын тайлангийн систем; 7. Татварын удирдлагын нэгдсэн систем. Ийнхүү систем хооронд холболт хийж, мэдээллийг шууд хүлээн авах боломжийг бүрдүүлснээр нийт системд оруулах мэдээллийн 60 гаруй хувийг автоматжуулан төсвийн байгууллагын мэдээлэл оруулах үүрэг бүхий албан хаагчдын ажлын ачааллыг хөнгөвчилж, мэдээллээ нийтлэхэд цаг хугацаа хэмнэх, мэдээллийн үнэн зөв байдал нэмэгдэх зэрэг эерэг үр дагавар бий болохоос гадна нөгөө талаас иргэдэд энгийн, ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдлаар шинэчилснээр иргэд, олон нийт нээлттэй мэдээллийг ашиглан дүн, шинжилгээ, судалгаа хийх боломж бий болсон.	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-
5.1.7.Гадаадын зээл тусламжтай холбоотой мэдээллийг	Ахиц дэвшил сул	СаЯ: Засгийн газрын гадаад зээл, тусламжийн мэдээллийн нэгдсэн цахим систем /ODAMIS/-ийг 2020 оны 12 дугаар сараас хойш	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу	Төслийн санхүүжилт, үр дүнгийн уялдааг

ODAMIS.mof.gov.mn системд бүртгэх, дэлгэрэнгүйгээр байршуулах, чиглэлийн уялдаа холбоог хангах, санхүүжилт болон үйл ажиллагааны үр дүнгийн уялдааг хангах, төслүүдийн худалдан авах үйл ажиллагааны журмыг олон нийтэд ил тод болгож сайжруулах		ашиглаж байна. Тус системээр Засгийн газрын гадаад зээл, тусламж, Засгийн газрын бус хүмүүнлэгийн, техник тусламжааны болон бусад тусламжийн төслийн удирдлагыг хэрэгжүүлж, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна. Тухайлбал: •Төсөл, арга хэмжээг төлөвлөх, төсөвлөх; •Хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах; •Санхүүжилтийн эрх нээх, гаалийн импорт болон дотоодын НӨАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүсэлтийг хянан шийдвэрлэх; •Нэгдсэн бүртгэл хөтлөх; •Хэрэгжилтийн явцад хяналт тавих, үнэлэх, тайлагнах; •Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтан, бие даасан зөвлөхийн гэрээний үүргийн биелэлт, зөрчилтэй холбоотой хяналтын бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагаа хийгдэж байна. Ил тод байдлыг хангах үүднээс “Олон нийтийн хандах эрх”-ийг тохируулж өгсөн бөгөөд хүссэн хүн бүр систем рүү орж, холбогдох мэдээлэлтэй танилцах боломжтой. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэгтгэж, нэгдсэн нэг системээр удирдан зохион байгуулахтай холбогдуулан 2024 оны IV улирлаас эхлэн ODAMIS системийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем /PIMIS/-тэй нэгтгэх хөгжүүлэлтийн ажлууд хийгдэж байна. Улмаар Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслүүдийн төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүхий л үйл ажиллагааг PIMIS системд бүрэн нэвтрүүлсэн. Мөн төслүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг шинэ дэд системийн өгөгдлийн санд бүртгэсэн. Шинэ дэд системд харуулах хөгжүүлэлтийн ажил 40%-тай үргэлжилж байна. ODAMIS систем дээр хийгдэж буй санхүүжилтийн үйл ажиллагааг PIMIS систем рүү шилжүүлэх судалгааны ажлууд үргэлжлэн хийгдэж байна.	хагас жилийн тайлан гаргах.	хангаж тайлагнах.
Зорилт 5.2.Орон нутгийн төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх				
5.2.1.Орон нутгийн төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхтэй холбогдсон арга хэмжээ авах	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	СаЯ: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд "иргэд орон нутгийн үйл хэрэгт шууд болон сонгож байгуулсан төлөөллийн байгууллагаараа уламжлан оролцох" гэж заасан, мөн тус хуульд нутгийн өөрөө удирдах байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн санаа бодлыг төрийн үйл хэрэгт тусгах, төсвийн төслийг хэлэлцэх үед иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, санал хураалт зохион байгуулах эрхийнхээ хүрээнд төсвийг боловсруулан ирүүлдэг. Мөн СЯ нь Орон нутгийн	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	Орон нутгийн хөгжлийн сан нь орон нутгийн төсвийн маш бага хэмжээтэй тэнцэх санхүүжилттэй байдаг тул ОНХС дахь иргэдийн оролцоо нь орон нутгийн төсвийн

		хөгжлийн сангийн удирдлагын мэдээллийн системийг үйл ажиллагаанд нэвтрүүлж, орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг цахимжуулж, ил тод, үр ашигтай, иргэдийн оролцоог хангах, хяналт тавих боломжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.		төсөлд иргэдийг төлөөлж чадахгүй байгааг анхаарах.
Зорилт 6.Нийгмийн бүх бүлэгт төрөөс үзүүлж буй үйлчилгээг оновчтой болгох				
6.1.Үйл ажиллагааны олон улсын ангилал (ICF)-ыг үе шаттай нэвтрүүлэх	Ахиц дэвшил сул	ГБХНХЯ: АХБ-ны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд “Үйлдлийн олон улсын ангилал /ICF/-ыг нэвтрүүлэх чиглэлээр Монгол Улсад хэрэгжүүлэхэд тохиромжтой сургалтын модуль, хөтөлбөр, гарын авлага, аргачлалыг 2023 онд боловсруулан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадварыг /ICF/-д суурилсан үнэлгээг турших сургалт”-ыг зохион байгуулсан. Сургалтад нийслэлийн 6 дүүрэг, 8 аймгийн ЭХМСК-ын магадлагч эмч, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга нарыг хамруулсан. Сургалтын үеэр хөгжлийн бэрхшээлтэй 30 хүнд туршилтын үнэлгээ хийсэн. Түүнчлэн 2024 оны 02 дугаар сарын 26-28-ны өдөр “Үйлдлийн олон улсын ангилал”-д суурилан хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрлөх чадварт үнэлгээ хийх арга хэрэгсэл сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтад 6 аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн албан хаагчид, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын албан хаагчид болон аймаг, дүүргийн эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн магадлагч эмч нар нийт 70 орчим хүнийг хамруулсан. Мөн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох “Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ҮАОУА)-ын талаарх талуудын уулзалт, хэлэлцүүлэг”-ийг 2024 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгууллаа. Тус хэлэлцүүлгийн үеэр Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангиллын танилцуулга, ҮАОУА-ын талаар зарим оронд хэрэгжүүлж буй байдал, ҮАОУА-ын цөм иж бүрдлийн талаарх танилцуулга, Эрүүл мэндийн салбарт Олон Улсын хөгжлийн бэрхшээлийн ангилал (ICD-11)-ыг нэвтрүүлж байгаа талаарх мэдээлэл, АХБ-ны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хийсэн “ҮАОУА-ыг нэвтрүүлэх, холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийг чадавхжуулах” зөвлөх үйлчилгээний мэдээллийг танилцуулсан.	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-(ICF)-ын аргачлалыг боловсруулах, үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх.

		2025 оны 5 дугаар сарын 02-ны өдөр ГБХНХЯ, ЭМЯ, БЯ-ны холбогдох мэргэжилтнүүдэд ICF-ийн зарим арга хэрэгслийг үйл ажиллагаанд ашиглаж эхэлж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв, ХБХЭМБНХ-ын комисс, БСҮХ, АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулиудын ажлын явцыг танилцуулах, харилцан мэдээлэл солилцох уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Уулзалт, хэлэлцүүлгээс ҮАОУА-ыг үе шаттай нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, салбар дундын хамтарсан ажлын хэсэг байгуулан, төлөвлөгөө гарган ажиллахаар тохиролцсон. Үүний дагуу ГБХНХ-ын сайдын тушаалаар салбар дундын ажлын хэсэг, үйл ажиллагааны удирдамжийг батлуулахаар ажиллаж байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд 2025 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгон зарласан бөгөөд жилийн ажлын хүрээнд хөдөлмөр эрхлэх сонирхолтой ХБИ-ийн бүртгэл, судалгааг зохион байгуулах гэж байна. Уг судалгааны асуулгыг ҮАОУА-ын үнэлгээний асуулгыг ашиглан боловсруулсан. Мөн уг аргачлалыг ХБИХЭДТ-өөс үйлчилгээ авах иргэдийн ур чадвар, хэрэгцээний үнэлгээнд ашиглахаар асуулга, гарын авлагыг боловсруулан туршиж байна. ХБХХЕГ: Үйл ажиллагааны олон улсын ангилал (ICF)-ыг үе шаттай нэвтрүүлэх ажлын хүрээнд ҮАОУА-д суурилсан хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрийн чадварын үнэлгээ хийх ажлыг авч хэрэгжүүлээд байна. Үүнд: ХБХХЕГ-ын харьяа “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв” нь 2025 оны 3 дугаар сард ҮАОУА-д суурилсан хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрийн чадварын үнэлгээний асуумжийг боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэн туршилтын судалгааг хийж байна. 2025 оны 5 дугаар сарын байдлаар нийт 34 иргэнээс тус асуумжаар судалгаа авч, дүгнэлт гаргасан байна.		
6.2.Институци буюу асрамжийн тогтолцоонд зориулсан төсөвлөлт, бодлого, үйл ажиллагааг нийгмийн хамгааллын дэмжлэг шаардлагатай иргэдийн бие даан	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	ГБХНХЯ: Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3-д заасны дагуу тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд сар бүрийн тэтгэмж 302,500 төгрөгийг нийгмийн халамжийн сангаас олгодог. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүний төрөлжсөн	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон түүнийг дагалдах хуулийн нэмэлт,

амьдрахад дэмжих тогтолцоонд шилжүүлэх, төлөвлөлтийг боловсруулах		асрамжийн газрын төвлөрлийг сааруулах, асрамжийн газарт олноор нь байрлуулан асрах биш гэр бүлийн орчинд, асралт гэр бүлд асрах бодлогыг хэрэгжүүлэн 2025 оны 4 дүгээр сарын байдлаар ганц бие иргэнийг гэр бүлдээ асарч байгаа нийт 193 иргэнд 221,065.6 төгрөгийн тэтгэмж олгосон байна. УИХ-аас 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр баталсан Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар ахмад настны эрүүл, идэвхтэй насжилтыг дэмжих, бие даан амьдрах чадварыг нэмэгдүүлэх хүрээнд тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн цогц үйлчилгээ болон байнгын асаргаа сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настнуудад асаргааны олон хувилбарт үйлчилгээг тусгасан холбогдох журмуудыг батлуулан 2025 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд бие даан амьдрах, өөрөө өөртөө үйлчлэх чадвартай ахмадуудыг идэвхтэй насжилтын төвийн үйлчилгээнд хамруулах, харин хөгжлийн бэрхшээлтэй, асаргаа сувилгаа шаардлагатай ахмад настныг төрөлжсөн асрамжийн газарт асрахаас гадна олон хувилбараар асаргаа үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Нийгмийн халамжийн багц хуулийн шинэчлэлийн хүрээнд Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон түүнийг дагаж өргөн мэдүүлэх хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж байгаа бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх, асралт гэр бүлд асрах, өдрөөр асрах, гэрт нь очиж асрах зэрэг олон хувилбарт үйлчилгээний зохицуулалтыг шинээр нэмж төсөлд тусгаад байна. Дээрх хуулийн төслийг иргэд, олон нийт, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөлд танилцуулан саналыг тусгасан. Мөн хуулиудын төсөлд яамдын саналыг авч тусган Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр ажиллаж байна.		өөрчлөлтийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх.
6.3.Зорилтот бүлгийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох суурь судалгааг хийх, судалгааны үр дүнд суурилсан нийгмийн халамжийн бодлого төлөвлөх	Ахиц дэвшил сул	ГБХНХЯ: Өрхийн мэдээллийн нэгдсэн сан: Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу ГБХНХ-ын сайдын тушаалаар нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг тодорхойлох судалгаа хийх аргачлалыг ҮСХ, ХНХ-ын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/16,А/04 тоот хамтарсан тушаалаар баталж, өрхийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлсэн. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний аж байдлын талаарх цогц судалгаа хийх.

		шаардлагатай өрхийн онооны босго шугамыг дээрх санг үндэслэн 401.2 болон түүнээс доош оноогоор тогтоосон. Босго шугамыг ашиглан: -Хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд олгох онцгой тохиолдлын тэтгэмж /61 иргэнд 73,200,000 төгрөг/ -Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бүрэн болон хэсэгчлэн төлөх -Хууль зүйн туслалцааны тухай хуульд заасан төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээг үзүүлж байна /Зөвлөгөө авсан 2700, өмгөөллийн үйлчилгээ авсан 3,204 иргэн байна/. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчлэл: “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална.” гэж заасан. Энэхүү бодлогын зорилттой уялдуулан зорилтот бүлгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх судалгааг ТУСС солюшн болон мэргэжлийн судлаач багш нарын оролцоотой хийж, өнөөгийн нөхцөл байдал, цаашдын шаардлага, эрх зүйн өөрчлөлт шинэчлэлийн талаар судалгаа хийж, дүгнэлт, бодлогын зөвлөмж гаргасан. Нийгмийн халамжийн тухай хуулийн үзэл баримтлалыг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр ХЗДХ-ийн сайдтай хамтран баталж, Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулсан. Хуулийн төсөлд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг томъёолсон. Тухайлбал, ахмад настанд олгох тэтгэвэр, асаргааны тэтгэмж, эрүүл мэндийн дэмжлэг, түлшний үнийн дэмжлэг зэргийг амьжиргааны түвшинтэй уялдуулахаар тусгасан. Мөн амьжиргаа багатай хэсэгт чиглэсэн бие даан амьдрах чадавхыг дэмжих урт хугацааны үйлчилгээ болон гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлийн сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээг шинээр боловсруулан оруулсан.			
6.4.Хүүхдийн тухай хууль, хэрэгжилтийг	эрхийн түүний хангах	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	ГБХНХЯ: 1.УИХ-аас 2024 оны 01 дүгээр сард Хүүхэд хамгааллын тухай хуулийн /Шинэчилсэн найруулга/ хамт Хүүхдийн эрхийн тухай	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу	-

бүтэц, чадавхийг нэмэгдүүлэх		хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталж, дараах өөрчлөлт орсон. -“20.3.Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшүүлсэн сургалтад хамрагдсан, тухайн чиглэлээр нэгээс доошгүй жил ажилласан, хүмүүнлэгийн болон нийгмийн ухаан, хууль зүйн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байна. -20.8.Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоог тухайн орон нутгийн хүн амын тоо, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хүүхдийн эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг харгалзан гурван жил тутамд Засгийн газраас тогтооно. -20.12.Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрмийг Засгийн газар батална.” гэж тус тус заасан. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд Засгийн газрын 2024 оны 142 дугаар тогтоолоор “Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрэм”, Засгийн газрын 2024 оны 143 дугаар тогтоолоор “Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоо”-г тогтоосон. Улсын хэмжээнд 2025 онд 48 хүүхдийн эрхийн улсын байцаагч ажиллаж байна. 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 92 хүүхдийн эрхийн улсын байцаагч ажиллах тул 2026 оны төсвийн урьдчилсан мэдэгдэлд төсвийн тооцооллыг тусгаж байна. 2.Мөн хуулийн 201 дүгээр зүйлд “Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч” сум, дүүргийн Засаг дарга баг, хороонд ажиллах эрх зүйн зохицуулалттай болсон. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газраас аймаг, дүүргийн Засаг дарга нарт чиглэл хүргүүлсэн.	хагас жилийн тайлан гаргах.	
6.5.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хамаарах хууль, журмын шинэчлэлийг үргэлжлүүлэх	Ахиц дэвшил сул	ГБХНХЯ: ГБХНХ-ын сайдын 2025 оны А/22 дугаар тушаалын хавсралтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хууль, Дохионы хэлний тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулж, хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслийг боловсруулж байна. Хуулийн үзэл баримтлалын төслийг ХЗДХ болон Сангийн сайдтай хамтран батлахаар бэлтгэсэн. ХБХХЕГ: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хамаарах хууль, журмын шинэчлэлийг үргэлжлүүлэх ажлын хүрээнд: Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хууль, Дохионы хэлний тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж батлах.

		ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын саналыг тусгах зорилгоор “Нэг асуудал, нэг шийдэл” хэлэлцүүлгийг 2025 оны 5 дугаар сарын 09-ны өдөр төр болон төрийн бус байгууллагын нийт 40 хүнд зохион байгуулан ажилласан. Хэлэлцүүлгээс гарсан төрийн бус байгууллагын нийт 13 саналыг хурлын тэмдэглэлийн хамт ГБХНХЯ-ны Хөдөлмөрийн бодлогын газрын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга Ю.Отгонбилэгт холбогдох имэйл хаягаар 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдөр хүргүүлж ажилласан.		
6.6.Төрийн үйл хэрэгт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх: -Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Үндэсний зөвлөл, дэд зөвлөл, салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, -Орон нутгийн иргэдийн хурлын дэргэд иргэний зөвлөлийг бий болгох	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	ГБХНХЯ: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн хурлыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, тус хурлаар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 1 дүгээр сард зохион байгуулсан 6 яамны дэд зөвлөлийн үйл ажиллагаанд хийсэн сонсголоос гарсан дүгнэлт, зөвлөмж, албан даалгаврыг танилцуулж, зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн дэх ТББ-ын төлөөлөлтэй тогтмол уулзалтыг зохион байгуулж, 2025 оны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. Зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд 6 аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн үйл ажиллагааны сонсголыг зохион байгуулахаар тусгасан бөгөөд эхний хагас жилд Хөвсгөл, Дундговь, Дархан-Уул, Дорнод аймгийн салбар зөвлөлийн сонсголыг зохион байгуулаад байна. Мөн ГБХНХЯ-ны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн хурлыг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулж, тус хурлаар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Дэд зөвлөлөөс 2025 онд эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд 9 арга хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх төрийн үйлчилгээг сайжруулах хүрээнд 6 арга хэмжээ, нийт 15 арга хэмжээг харьяа агентлаг болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийн шатандаа байгаа 13 арга хэмжээ байна. ХБХХЕГ: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Үндэсний зөвлөл, дэд зөвлөл, салбар зөвлөлийн үйл ажиллагааг	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Үндэсний зөвлөл, дэд зөвлөл, салбар зөвлөлийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн тогтмолжуулах, -Орон нутгийн иргэдийн хурлын дэргэд иргэний зөвлөлийг бий болгох ажлыг үргэлжлүүлэх.

		тогтмолжуулах 2025 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн хурал 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр хуралдаж 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөний 3 зорилтын хүрээнд: 1.Бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгох 2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээг сайжруулах 3.Дэд, салбар зөвлөлийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх зэрэг 19 ажлыг төлөвлөсөн. 2025 оны хагас жилийн байдлаар Дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах ажлын хүрээнд БЯ, СЯ, ХББОСЯ, ССАЖЗЯ, ЦХИХХЯ, ЭМЯ-ны дэд зөвлөл, Хөвсгөл, Дундговь, Дархан-Уул аймгийн салбар зөвлөлүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх тайланг хэлэлцэх сонсголыг зохион байгуулсан. 2025 онд багтаан Архангай, Дорнод, Ховд аймаг, Нийслэлийн 6 дүүрэгт сонсголын арга хэмжээ зохион байгуулна. Бүх яамдын дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга нартай үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, санал солилцох уулзалтыг зохион байгуулан ажиллаж байна. Жил бүрийн 12 дугаар сарын 03-ны Дэлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийг угтан 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр Төрийн ордонд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн ивээл дор "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, оролцоо-2024 үндэсний чуулган, "Ability expo-2024", "Тогтвортой хөгжил, эрх тэгш оролцоо, олон талт байдлыг дэмжих" арга хэмжээ, Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй "Оны шилдэг" шалгаруулах арга хэмжээг зохион байгуулсан. Jobcenter-ийн үндэсний сүлжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт нээсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөл нь аймаг, нийслэл, дүүрэгт салбар зөвлөл, төрийн захиргааны төв байгууллагын дэргэд дэд зөвлөлтэй үйл ажиллагаа явуулдаг. Үндэсний зөвлөлийн хурлаар өнгөрсөн оны төлөвлөгөөний хэрэгжилтийг дэд болон салбар зөвлөлүүдээс авч, нэгдсэн дүн гаргаж танилцуулан, ирэх оны төлөвлөгөөг баталдаг. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг улирал бүрээр авч хагас, бүтэн жилээр дүгнэдэг. 2025 онд 6 яамны дэд зөвлөл, 3 аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны сонсголыг анх удаа зохион байгуулж, зөвлөл тус бүрд зөвлөмж хүргүүлсэн.		
--	--	--	--	--

6.7.Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даан амьдрах тогтолцооны суурийг тавих: -Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрахад дэмжих үйлчилгээг хэрэгжүүлж эхлэх, шинэчлэх; -Үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг чадвахжуулах сургалт, дадлага явуулах; -Тухайлсан нийгмийн бүлгүүдэд зориулсан “орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	ГБХНХЯ: УИХ-аас 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр баталсан Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар ахмад настны эрүүл, идэвхтэй насжилтыг дэмжих, бие даан амьдрах чадварыг нэмэгдүүлэх хүрээнд тэдний хэрэгцээ шаардлагад үндэслэн Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн цогц үйлчилгээ болон байнгын асаргаа сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настуудад асаргааны олон хувилбарт үйлчилгээг тусгасан холбогдох журмуудыг батлуулан 2025 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ГБХНХ-ын сайд, ЭМ-ийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/76,515, А/75,514 дүгээр хамтарсан тушаалаар “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”, “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам”, 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/28, 27 дугаар хамтарсан тушаалаар “Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах журам”, ГБХНХ-ын сайд, Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/51,37 дугаар хамтарсан тушаалаар “Үйлчилгээний жишиг үнэ, иргэний хариуцах төлбөрийн хэмжээ”-г тус тус баталсан. Ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээ болон асаргааны хувилбарт үйлчилгээнд зориулж 2025 оны нийгмийн халамжийн сангийн төсөвт 5.0 тэрбум төгрөгийг батлуулан, 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32.2-т “Хувийн туслах үйлчилгээ, зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээгээр хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрх нь хангагдана” гэсэн заалтыг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүнд хувийн туслахын үйлчилгээ үзүүлж бие даан нийгмийн харилцаанд оролцоход нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. 2024 онд хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй 32 хүнд хувийн туслахын үйлчилгээ үзүүлсэн. 2025 онд Хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөр эрхэлж буй 50 орчим хүнд хувийн туслахын үйлчилгээ үзүүлэхээр 740,000,000 төгрөгийг ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	Тухайлсан нийгмийн бүлгүүдэд зориулсан “орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах
--	---	--	---	---

		хөтөлбөрийн төсөвт тусган батлуулсан. Үүнтэй холбогдуулан хувийн туслах бэлтгэх сургалт, үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг зохион байгуулах сонгон шалгаруулалтыг 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр зарлаж, шалгарсан төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллаж байна. ХБХХЕГ: 1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрахад дэмжих үйлчилгээг хэрэгжүүлж эхлэх, шинэчлэх: -Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.6-д “Байнгын асаргаа шаардлагатай иргэн гэж бусдын тусалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүнийг хэлнэ” гэж заасны дагуу эдгээр хүүхэд эмчилгээ, сувилгаа өдөр тутам шаардлагатайгаас гадна эрүүл мэндийн үйлчилгээ байнга авч байдаг тул байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн санал, гомдол, хэрэгцээ, шаардлагыг үндэслэн дугаарын хязгаарлалтгүй зорчих 2024 оны зөвшөөрлийн бичгийг Замын хөдөлгөөний удирдлагын төвтэй хамтран олгож эхлээд байна. 2025 оны эхний хагас жилд 512 эцэг, эхийн материалыг бүрдүүлэн хүлээн авч нэрсийн жагсаалтыг, цахим мэдээллийн хамт Замын хөдөлгөөний удирдлагын төвд бүртгэлжүүлэн илгээж, зөвшөөрлийн бичгийг олгоод байна. 2.Үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг чадвахжуулах сургалт, дадлага явуулах ажлын хүрээнд 2025 оны 4 дүгээр сарын байдлаар Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, нөлөөллийн сургалтыг төр, хувийн хэвшлийн 12 байгууллагын 280 хүнд зохион байгуулсан байна. 3.Тухайлсан нийгмийн бүлгүүдэд зориулсан “орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд ХНХ-ын сайд, БХБ-ын сайдын хамтарсан 2023 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн А/102, 1064 тоот тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх” хөтөлбөр батлагдсаны дагуу ХБХХЕГ 2025 оны 5 дугаар сарын байдлаар 155 хөгжлийн бэрхшээлтэй иргэний өргөдөл, хүсэлт, холбогдох материалыг хүлээн аваад байна.		
--	--	---	--	--

6.8.Хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд нийцүүлэн боловсролын үзэл хандлага, сургалтын орчин, багшийн сургалтын арга зүйг бий болгох	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	БЯ: Сургуулийн өмнөх боловсрол: Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал” батлагдсан. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд Боловсролын сайдын 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн "Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, сурах бичгийн зохиох, хянах багийн бүрэлдэхүүн батлах тухай" А/06 дугаар тушаалаар сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний хөтөлбөрийг боловсруулан нийслэлийн 6, аймаг, сумын 12 нийт 18 цэцэрлэгт 2024-2025 оны хичээлийн жилд туршин хэрэгжүүлсэн. Энэхүү сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний хөтөлбөрийн шинэчлэл нь суралцахуй болон багшлахуйд гарч буй өөрчлөлт, хүүхэд бүрийн онцлог, ялгаатай хэрэгцээнд нийцүүлэх, сургалтын арга зүйн, технологид гарч буй өөрчлөлт шинэчлэлийг багш, эцэг эхийн оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэж байна. Ерөнхий боловсролын сургууль: Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-ыг (2024-2036) баталсан. Энэхүү үзэл баримтлалд нийцүүлэн 2024-2025 оны хичээлийн жилд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс сургуулийн өмнөх болон бага боловсролын сургалтын хөтөлбөрийн төслийг боловсруулан тохирц, нийцлийг 18 цэцэрлэг, ерөнхий боловсролын 27 сургуульд шалган турших үйл ажиллагааг зохион байгуулсан. Туршилтын үр дүн болон экспертийн санал дүгнэлтийг тусган сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн 1-2 дугаар ангийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөлд Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.6, Боловсролын ерөнхий хуулийн 23.3-т заасан Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг авах үйл ажиллагааг зохион байгуулж байна. Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд үзэл баримтлалд тусгасан дараах шаардлагыг боловсруулахыг зорьсон. Үүнд: -Сургалтын хөтөлбөрийг суралцахуйн загварын онол, бодит суралцахуйн онол болон конструктивист онолд суурилж боловсруулах;	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-
--	---	---	---	----------

		-Практик үйлд баримжаалсан, суралцагчийн амьдрал, хөгжилд ач холбогдолтой сургалтын идэвхтэй арга зүйг санал болгосон, жишээгээр тайлбарласан байх; -Суралцагчийн хөгжлийг дэмжсэн сургалтаас гадуурх үйл ажиллагааг жишээ, удирдамжтайгаар санал болгосон байх; -Сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд тэгш хамруулах зарчим, арга зүйг баримтлах; -Суралцагч бүрд адил тэгш боломж бүрдүүлэх зорилгоор тэдний ялгаатай хэрэгцээг харгалзан, сургалтын хөтөлбөрт талуудын оролцоотой тохируулга хийж, хэрэгжүүлэх зэрэг болно. Энэ удаагийн сургалтын хөтөлбөрийн гол шинэчлэл нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд заасан чадамжийг хөгжүүлэхтэй холбоотойгоор сургалтын хөтөлбөрийн арга зүйн өөрчлөлт юм. Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах үйл ажиллагаа 2025-2029 онд үе шаттай үргэлжилнэ. Тэгш хамран сургах чиглэлээр: 2024-2025 оны хичээлийн жилийн статистик мэдээллээр ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй нийт 627 суралцагч суралцаж байна. Засгийн газрын "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай" 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам"-ын дагуу өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагч, хүүхдэд ногдох хувьсах зардлыг гурав дахин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнээс хамаарсан боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг 75 хувь, цэцэрлэгийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээг 30 хувиар тус тус нэмэгдүүлэн санхүүжүүлж байна. Энэхүү нэмэгдэл санхүүжилтийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тохируулгат орчин бүрдүүлэхэд зарцуулж байна. БШУ-ны сайдын 2024 оны "Туршилт зохион байгуулах тухай" А/60 дугаар тушаалаар 2023-2024 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын танхимын		
--	--	---	--	--

		сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй 78 хүүхдэд тухайн түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт тохируулга хийж, ганцаарчилсан сургалтыг туршилтаар зохион байгуулах арга хэмжээ авч, төр болон хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Ээлтэй ертөнц”, “Эрхэм нандин сувд”, “Энэрлийн түүчээ”, “Аутизмд хийсэн аялал” ТББ-уудтай хамтран хэрэгжүүлсэн. Энэхүү туршилтын үйл ажиллагааг Боловсролын сайдын 2024 оны “Туршилтын үйл ажиллагааг сунгах тухай” А/58 дугаар тушаалаар 2024-2025 оны хичээлийн жилд үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Боловсролын ерөнхий хуулийн 17.9-д “Боловсролын, эрүүл мэндийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төв ажиллуулж болно.”, 17.10-д “Энэ хуулийн 17.9-д заасан дэмжих төвийн үйл ажиллагааны зардлыг боловсролын, эрүүл мэндийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран санхүүжүүлнэ” гэж тус тус заасан. Иймд Боловсролын сайд, ЭМ-ийн сайд, ГБХНХ-ын сайдын 2025 оны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрэм”-ийг А/85, А/55, А/49 дүгээр хамтарсан тушаалаар хамтран баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2025 оны 7169 дугаарт бүртгүүлээд байна. Боловсролын яам, ЭМЯ, ГБХНХЯ-ны холбогдох нэгж, хэрэгжүүлэгч агентлагын албан хаагчдын уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмшихэд цогц дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэн үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна.		
Зорилт 7.Ардчилсан нийгэмд нээлттэй өгөгдлийн соёл цогцлоох				
7.1.Нээлттэй өгөгдлийн шаардлага, стандартыг батлах	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	ЦХИХХЯ: УИХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль батлагдаж, 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан ЦХИХХЯ тус хуулийн 12 дугаар зүйлд заасан нээлттэй өгөгдлийн чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлээд байна. Үүнд: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.5 дахь хэсэгт “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх, ашиглах нөхцөл, журам, нээлттэй өгөгдөлд тавигдах шаардлага болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-

		системийн үйл ажиллагааны журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан Засгийн газар батална.” гэж заасны дагуу Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн “Журам батлах тухай” 200 дугаар тогтоолоор “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам” болон “Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус батлуулан, хэрэгжүүлж байна. Засгийн газар мэдээллийн технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа оновчтой ашиглах замаар төрийн үйлчилгээг илүү үр ашигтай, ил тод, хүртээмжтэй болгох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, эдийн засгийн боломжийг бий болгох, баялаг бүтээх, инновацыг дэмжих зорилгоор төрийн өгөгдлийг иргэдэд нээлттэйгээр ашиглуулах төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал “opendata.gov.mn”-ын 2.0 хувилбарыг 2024 оны 3 дугаар сард ашиглалтад оруулан, төрийн байгууллагын нээлттэй өгөгдөл хариуцсан 41 албан хаагч нарт 3 удаагийн танхим болон цахим хосолсон сургалтыг зохион байгуулсан. Засгийн газрын 200 дугаар тогтоолоор батлагдсан журмын 5.1 дэх хэсэгт “Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх, шинэчлэх ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулж, хариуцсан албан хаагчийг томилж, ажиллуулна.” гэж заасан бөгөөд хүний нөөцийн бэлэн байдлыг хангах зорилгоор 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01/99 албан бичгийг мэдээлэл хариуцагч байгууллагад хүргүүлж, 58 байгууллага хариу ирүүлэхээс 35 байгууллага буюу 60% нь ирүүлсэн. Өнөөдрийн байдлаар тэдгээр 35 байгууллагын нээлттэй өгөгдөл хариуцсан албан хаагчдад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.6 дахь хэсэгт “Нээлттэй өгөгдлийн жагсаалт, нээлттэй өгөгдлийг нийтлэх хугацааг Засгийн газар тогтооно.” гэж заасны дагуу Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн “Журам батлах тухай” 232 дугаар тогтоолоор 59 байгууллагын 606 төрлийн нээлттэй өгөгдлийн жагсаалт, түүнийг нийтлэх хугацааг баталсан. Тус тогтоолыг 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн “Жагсаалт шинэчлэн батлах тухай” 96 дугаар тогтоолоор 58 байгууллагын 691 төрлийн нээлттэй өгөгдөл байршуулахаар шинэчлэн батлуулсан. Энэхүү тогтоолоор		
--	--	---	--	--

		нээлттэй өгөгдлийг төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал “opendata.gov.mn”-д тогтоосон хугацаанд байршуулж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, УИХ-аас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсөн. Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал (opendata.gov.mn)-д 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар нийт 58 байгууллага өгөгдөл байршуулахаас 54 байгууллага буюу 91.3% нь 3,193 өгөгдлийг байршуулсан ба тус өгөгдлийг иргэд, олон нийт 282,081 удаа татан авсан байна		
7.2.Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (opendata.gov.mn)-д өгөгдлөө нийтэлж буй мэдээлэл хариуцагч төрийн байгууллагуудын нээлттэй өгөгдлийн бүрдэл, чанар, стандартыг тогтмол үнэлэх	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	ЦХИХХЯ: Монгол Улсын Засгийн газар мэдээллийн технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа оновчтой ашиглах замаар төрийн үйлчилгээг илүү үр ашигтай, ил тод, хүртээмжтэй болгох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, эдийн засгийн боломжийг бий болгох, баялаг бүтээх, инновацыг дэмжих зорилгоор төрийн өгөгдлийг иргэдэд нээлттэйгээр ашиглуулах төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал “opendata.gov.mn”-ын 2.0 хувилбарыг 2024 оны 03 дугаар сард ашиглалтад оруулан, төрийн байгууллагын нээлттэй өгөгдөл хариуцсан 41 албан хаагч нарт 3 удаагийн танхим болон цахим хосолсон сургалтыг зохион байгуулсан. Засгийн газрын 200 дугаар тогтоолоор батлагдсан журмын 5.1 дэх хэсэгт “Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх, шинэчлэх ажлыг ба гууллагын хэмжээнд зохион байгуулж, хариуцсан албан хаагчийг томилж, ажиллуулна.” гэж заасан бөгөөд хүний нөөцийн бэлэн байдлыг хангах зорилгоор 2025 оны 01 сарын 16-ны өдрийн 01/99 албан бичгийг мэдээлэл хариуцагч байгууллагуудад хүргүүлж, 58 байгууллага хариуг ирүүлэхээс 35 байгууллага буюу 60% нь ирүүлсэн. Өнөөдрийн байдлаар тэдгээр 35 байгууллагын нээлттэй өгөгдөл хариуцсан албан хаагчдад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.6 дахь хэсэгт “Нээлттэй өгөгдлийн жагсаалт, нээлттэй өгөгдлийг нийтлэх хугацааг Засгийн газар тогтооно.” гэж заасны дагуу Монгол улсын Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн “Журам батлах тухай” 232 дугаар тогтоолоор 59	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-

		байгууллагын 606 төрлийн нээлттэй өгөгдлийн жагсаалт, түүнийг нийтлэх хугацааг батлуулсан. Тус тогтоолыг 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн “Жагсаалт шинэчлэн батлах тухай” 96 дугаар тогтоолоор 58 байгууллагын 691 төрлийн нээлттэй өгөгдөл байршуулахаар шинэчлэн батлуулсан. Энэхүү тогтоолоор нээлттэй өгөгдлийг төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал “opendatagov.mn”-д тогтоосон хугацаанд байршуулж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсөн. Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал (opendata.gov.mn)-д 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар нийт 58 байгууллага өгөгдөл байршуулахаас 54 байгууллага буюу 91.3% нь 3,193 өгөгдлийг байршуулсан ба тус өгөгдлийг иргэд, олон нийт 28,2081 удаа татан авсан байна.		
Зорилт 8.Төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдийн сэтгэл ханамжаар тогтмол дүгнэж, оролцоог нэмэгдүүлэх				
8.1.Иргэдийн сэтгэл ханамжийг тогтмол дүгнэж, түүнд тулгуурлан төрийн үйлчилгээний сайжруулалтыг тухай бүр уян хатан байдлаар хийдэг болох	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	ХҮҮХ: ЗГХХГ-аас иргэдийн сэтгэл ханамжийг хэмжих, түүнд тулгуурлан төрийн үйлчилгэний сайжруулалтыг тухай бүр уян хатан байдлаар зохион байгуулах ажлын хүрээнд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын тайлан болон БОУАӨЯ, түүний харьяа Ойн газар, тэдгээрийн орон нутаг дахь зарим газар, нэгж, нутгийн захиргааны байгууллагаас үйлчилгээ авсан иргэн, аж ахуй нэгж байгууллагуудаас авсан судалгаанаас иргэн, аж ахуй нэгж байгууллагад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлж, сэтгэл ханамжийг хэмжин, цаашид авч хэрэгжүүлэх санал зөвлөмжийг боловсруулсан. 1. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын тайлангийн хүрээнд: -ЗГХХГ-аас “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай”, “Засгийн газар дахь хяналтын тухай” хууль, “Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын хүрээнд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтан болон Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдлын тайлан мэдээг нэгтгэж, Засгийн газрын хуралдаанд	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	-

		танилцуулан ажиллаж байна. Тайлан мэдээг нэгтгэхдээ гомдлын агуулгыг гарган, хамгийн их өргөдөл, гомдол ирүүлсэн салбар болон аймгуудыг сонгон, иргэдээс санамсаргүй түүвэр хийж, гомдлын шийдвэрлэлтийн чанар байдалд тандалт судалгаа явуулсан. 2024 онд төрийн байгууллага, албан тушаалтанд нийт 446374 иргэн хандаж өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 419658 буюу 94.0 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн байна. Нийт өргөдөл, гомдлын 67.5 хувийг хүсэлт, 18.9 хувийг гомдол, 11.4 хувийг мэдэгдэл, 2.0 хувийг санал тус тус эзэлж байна. Гомдол гаргасан иргэдээс түүвэрт 1066 иргэнийг сонгон, 621 иргэнтэй холбогдсон бөгөөд 54.2 хувь нь тухайн иргэний гомдлыг шийдвэрлэсэн гэж хариулсан бол шийдвэрлэлт хангалтгүй, дутуу зэргээр сэтгэл ханамжгүй байгаагаа 63.6 нь илэрхийлсэн. Мөн эрчим хүчний үнэ тарифыг өртөгт нь ойртуулах арга хэмжээтэй холбоотой цаг үеийн нөхцөл байдлыг тандан судлах зорилгоор “Иргэд олон нийттэй харилцах төв 11-11” төвд эрчим хүчний салбартай холбоотой 2024 онд ирүүлсэн өргөдөл, гомдлын дата, мэдээллийг авч, дүн шинжилгээ хийлээ. Тус салбартай холбоотой 1652 өргөдөл, гомдол ирүүлсний 1532 буюу 92.3 нь гомдол байгаа бөгөөд нийт гомдлын 95.5 хувь Улаанбаатар хотын иргэдийн гомдол байна. Ирүүлсэн гомдлын 474 буюу 30.9 хувь нь тогны мөнгө, төлбөр, 515 буюу 33.6 хувь нь цахилгааны хязгаарлалт, 227 буюу 14.8 хувь нь тоолууртай холбоотой асуудлаар ирсэн бөгөөд ирүүлсэн өргөдөл гомдлыг дунджаар 11.4 хоногт шийдвэрлэж ажилласан байна. Төрийн байгууллагаас гарч буй тогтоол, шийдвэр, мэдээ, мэдээллийг иргэдэд энгийн, хялбар, ойлгомжтой хэлбэрээр хурдан, шуурхай хүргэх үйл ажиллагаа хангалтгүй, иргэд ойлголтын зөрүүтэй байдлаас болж цаг үеийн асуудлаар гарах өргөдөл, гомдлын тоо ихэссэн байна. Цаашид өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн байдлаар хянаж, давхардлыг тогтоон, дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тодруулах, хариу арга хэмжээ авах, иргэдийн сэтгэл ханамжийг судлах боломжийг бүрдүүлсэн нэгдсэн цахим систем хөгжүүлэх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай. -ЗГХХГ-ын даргын 2025 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн А/75 тушаалаар өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан мэдээлэл гаргах, хүргүүлэх журмыг боловсруулж,		
--	--	---	--	--

		батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан ба тус журамд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд дүн шинжилгээ хийхэд иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг судалсан байдлыг тусгахаар ажиллаж байна. -ЗГХХГ-ын 2025 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн А/62 тушаалаар төрийн байгууллага, албан тушаалтны 2024 оны үйл ажиллагаа чанартай, хүртээмжтэй, шуурхай байсан эсэхэд хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах хүрээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын бүртгэл, шийдвэрлэлт, тайлагналтын байдал, иргэдийн сэтгэл ханамжийг тандан судалсан байдалд удирдамжийн дагуу үнэлгээ өгч, үнэлгээний үр дүнг Үнэлгээ, мониторингийн газарт хүргүүлж ажилласан. 2. Байгаль орчны салбарт хийгдсэн Процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээний ажлын хүрээнд: Байгаль орчны салбарт хийгдэж буй Процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээний ажлын хүрээнд тус салбараас тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж буй 2000 гаруй аж ахуйн нэгж, байгууллагаас санамсаргүй түүврийн аргаар 300 орчим аж ахуйн нэгж, байгууллагатай холбогдон судалгааны ажлын зорилгыг танилцуулж, мэдээлэл өгснөөс фокус бүлгийн ярилцлагад 82 аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг хамруулсан. Мөн тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж буй 150 гаруй байгууллагатай холбогдон /цахим судалгаа/ байгаль орчны салбараас үйлчилгээ авахад тулгарч буй хүндрэл бэрхшээл, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, албан хаагчдын үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлүүлж, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын сэтгэл ханамжийг үзүүлэлтийг тооцсон. Тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж байгууллагын судалгааг цахимаар авсан бөгөөд иргэн, аж ахуй нэгж байгууллагаас үйлчилгээ үзүүлсэн албан хаагч, тухайн авсан үйлчилгээ, үйлчилгээ үзүүлсэн байгууллагатай холбоотой 14 үзүүлэлтээр сэтгэл ханамжийн үнэлгээг тодорхойлсон. Судалгаанд хамрагдсан иргэн, аж ахуй нэгж байгууллагын судалгаанд хамрагдсдын 47.1 хувь нь БОУАӨЯ, 29.4 хувь нь Ойн газар, 11.8 хувь нь Усны газар, 35.3 хувь нь аймаг, нийслэлийн Байгаль орчны газар, 17.6 хувь нь Сум болон сум дундын ойн ангиас давхардсан тоогоор үйлчилгээ авсан байна. Судалгаанд хамрагдсан иргэн, аж ахуй нэгж байгууллагын 41.2 хувь нь ямар нэгэн хүндрэл учирсан, 58.8 хувь нь хүндрэл гараагүй гэж хариулсан байна. Хүндрэл учирсан гэж хариулсан иргэн, аж ахуй нэгж байгууллагын ихэнх нь хугацаандаа үйлчилгээ авч		
--	--	--	--	--

		чаддаггүй, салбарын байгууллага хоорондын харилцан уялдаа байхгүй, нэг бичиг баримтыг цаасаар, цахимаар, олон давтамжтай авдаг, хянан шалгах үйл ажиллагааны гомдол гаргаад түүний араас олон удаагийн шат дараалсан албан бичиг өгч гомдол санал шийдэгдэхгүй байна гэж хариулсан байна. Иргэн, аж ахуй нэгж байгууллага үйлчилгээтэй холбоотой ерөнхий үнэлгээнд 36.9 хувь нь сайн гэж үнэлсэн байна. Үйлчилгээний үнэлгээг нарийвчилж үзвэл бүрдүүлэх бичиг баримтын шаардлага өнөөгийн нөхцөл байдалтай уялдаж буй байдлыг 42.9 хувь нь төрийн байгууллагаас шалтгаалсан асуудал гарсан үед хаана, хэнд хандах талаар мэдээллийн нээлттэй байдлыг 28.6 хувь нь сайн гэж үнэлсэн байна. Байгаль орчны салбараас үйлчилгээ авсан арван иргэн, аж ахуй нэгж байгууллага тутмын зургаа (60.7 хувь) нь үйлчилгээ үзүүлсэн албан хаагчдыг сайн гэж үнэлсэн байна. Албан хаагчдын үнэлгээг нарийвчилж үзвэл албан хаагчдын мэдлэг, ур чадвар, мэргэшсэн байдлыг 57.1 хувь нь, харилцаа, хандлага, ёс зүйтэй байдлыг 64.3 хувь нь сайн гэж үнэлсэн байна. Мөн байгаль орчны салбарын төрийн байгууллагын уялдаатай ажиллаж буй байдлыг 28.6 хувь нь, байгууллага, албан хаагчийн асуудал шийдвэрлэж буй байдалд 28.6 хувь нь сайн гэж үнэлсэн байна. Төрийн үйлчилгээний цахимжуулалтын үр дүн, ач холбогдолтой байдалд судалгаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын 21.4 хувь нь сайн, 35.7 хувь нь дунд, 42.9 хувь нь муу гэж үнэлсэн нь төрөөс үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйлчилгээ авагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор цахимжуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Байгууллагын соёл, хамт олны уур амьсгалыг дээшлүүлэх бүтээлч ажил, албан хаагчдын шинэ санал санаачилга, мэдлэг, ур чадварыг бодитоор дэмжих арга хэмжээг тогтмол зохион байгуулж хэвших шаардлагатай байна. Энэхүү судалгааны ажлын хүрээнд авагдсан мэдээлэл, харьцуулсан дүн шинжилгээ, хэсэг бүрт хийгдсэн болон нэгдсэн дүгнэлт, санал, зөвлөмжийг тодорхой төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар хэрэгжүүлснээр Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, олон улсын гэрээ,		
--	--	---	--	--

		конвенцийг хэрэгжүүлэх төлөвлөлтийн уялдаа, хэрэгжилт сайжрах, оновчтой бүтэц, зохион байгуулалт бүрдэх, эрх зүйн орчин боловсронгуй болох, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжрах, мэдээллийн сан, түүний хөгжүүлэлт, ашиглалтад ахиц гарах, төсөл, хөтөлбөрийн бодит үр нөлөө нэмэгдэж, бодлого тодорхойлох болон хэрэгжүүлэх түвшинд хамтран ажиллах, мэдлэгт суурилсан, олон талын оролцоог хангасан орчин бүрдэх, төрийн үйлчилгээ авч буй иргэд, аж ахуйн нэгж болон төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр, дэмжлэг болно гэж үзэж байна.		
Зорилт 9.Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлыг нэмэгдүүлэх				
9.1.ИНБ, ТББ болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоог төрийн байгууллагын гүйцэтгэлийн удирдлага, үнэлгээ, мониторинг болон бодлогын үнэлгээ, мониторингид бий болгох	Ахиц дэвшил сул	ХҮҮХ: 1.ЗГХХГ нь Монголын Үнэлгээний холбоотой 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр ХБНГУ-ын Хөгжлийн үнэлгээний байгууллагатай хамтран “Улсын үнэлгээний чадавхын индекс” (INCE)-ийг тогтоох, Дэлхийн банкны Олон улсын үнэлгээний санаачилга (GEI)-ын дэмжлэгтэйгээр Мониторинг, үнэлгээний тогтолцооны шинжилгээ (MESA)-г хэрэгжүүлэх, Мониторинг, үнэлгээний чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, хөгжлийн бодлогын үнэлгээ хийхэд цаашид хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, баталгаажуулсан; 2.ЗГХХГ, Монголын Үнэлгээний холбоо, ХБНГУ-ын Хөгжлийн үнэлгээний байгууллагатай хамтран Монгол Улсын үнэлгээний чадавхын индекс (INCE)-ийг тогтоолгох үнэлгээг 2025 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эхлүүлсэн ба үнэлгээний тайланг 2025 оны 5 дугаар сарын 14-ны өдөр Төрийн ордонд үндэсний чуулган зохион байгуулж танилцуулсан. Үнэлгээнд ЕТГ, УИХ, тэдгээрийн харьяа байгууллага, Засгийн газар, яам, агентлаг, аймаг нийслэлийн Засаг даргын Тамгын газар, төрийн өмчит компани, их дээд сургууль, иргэний нийгмийн болон олон улсын байгууллага, судалгаа, үнэлгээний компани зэрэг нийт 164 байгууллага оролцсон.	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	ИНБ, ТББ болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоог төрийн байгууллагын гүйцэтгэлийн удирдлага, үнэлгээ, мониторинг болон бодлогын үнэлгээ, мониторингид бий болгох ажлыг эрчимжүүлэх.
9.2.Бодлогын уялдаа, нийцлийг хангах, зөрчлийг арилгах, тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэх олон талын хэлэлцүүлгийн механизмтай болох	Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн	ЭЗХЯ: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль батлагдсанаар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь дэвшүүлсэн зорилго, зорилтоо хангахад чиглэгдсэн, харилцан уялдаа бүхий урт, дунд, богино хугацааны гэсэн 3 төрөлтэй байхаар хуульчлагдсанаар хөгжлийн бодлого, төлөвлөлт нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх боломж бүрдсэн. Хөгжлийн бодлого,	Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хагас жилийн тайлан гаргах.	Тайланд дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлэх.

		төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.13 дахь заалтад "...хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэд, сонирхлын бүлгийн оролцоог ханган боловсруулсан байх"-аар заасны дагуу "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө", "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө" зэрэг хөгжлийн дунд болон богино хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн төлөөллөөр хэлэлцүүлэн, бүх талын оролцоог хангасан хэлэлцүүлгүүдийг тогтмол зохион байгуулж ирлээ. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг боловсруулахад бодлогын уялдаа, нийцлийг хангах хүрээнд УАГ гүйцэтгэл, нийцлийн аудитын газраас гаргадаг дүгнэлт, зөвлөмжийн дагуу зөрчлийг арилгахад анхааран ажилласан. Мөн ҮСХ, ЗГХХГ-тай хамтран бодлогын уялдаа, нийцлийг хангах, зөрчлийг арилгах талаар хамтран ажилласан болно. Мөн тус төлөвлөгөөг тогтвортой хөгжлийн 16 зорилттой бүрэн нийцүүлэн боловсруулсан.		
Сургамж				
Хоёр жилийн хэрэгжилтийн хугацаанд үр дүнтэй хэрэгжилтийг хангахын тулд хангалттай нөөц, чадавхийг бүрдүүлэх нь онцгой чухал бөгөөд энэ нь Монгол Улсын анхны дөрвөн жилийн төлөвлөгөө гэдгээрээ онцлогтой юм. Туршлагаас харахад дэмжлэг хангалтгүй бол үүрэг амлалтаа бодитой ахиулна гэдэг хүндрэлтэй байдаг. Мөн хэрэгжилтийн хугацаанд 2024 оны УИХ-ын сонгуулийн улмаас төрийн байгууллагын удирдлага солигдож, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт гарсан нь шийдвэр гаргах үйл явц, уялдаа холбоо, тасралтгүй байдалд сорилтыг бий болгодог. Улс төрийн орчны энэ өөрчлөлттэй зохицон уян хатан хяналтын механизм, бат бөх институцийн санах ойг бий болгох шаардлага нэмэгдэж байна. Ингэснээр улс төр, захиргааны өөрчлөлтийн хүндрэлийг даван туулахад үйл ажиллагааны төлөвлөгөө алдагдалгүй хэрэгжих нөхцөл бүрднэ.				
Зөвлөмж				
Сонгуулийн цикл, удирдлагын шилжилтийн нөлөөг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд саадгүй байлгахын тулд хэрэгжилтийн тасралтгүй байдал, тууштай үүрэг амлалтыг хэргэхжүүлэх институци буюу механизм байгуулахыг ХБТМ зөвлөж байна. Үүнд төрийн албаны байнгын бүтэц дэх үүрэг, хариуцлагыг албан ёсоор тогтоох, улс төрийн нам хоорондын дэмжлэгийн тогтолцоог бий болгох, үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилтыг үндэсний хөгжлийн бодлогод нэгтгэх зэрэг арга хэмжээ орно. Мөн ажил үүргийг шилжүүлэн өгөх үйл явцыг зохион байгуулж, албан тушаалтнуудын уялдаа холбоог сайжруулах нь улс төр, бүтцийн өөрчлөлтөөс үүдэлтэй тасалдал, саад бэрхшээлийг бууруулахад чухал нөлөөтэй.				

Монгол Улсын Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний үр ашиг, амжилтыг дээшлүүлэхийн тулд 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө Монголын НЗТ-ийн Дэмжих нэгж болон Үндэсний зөвлөлд хангалттай санхүү, техник, хүний нөөцийн баталгааг бүрдүүлэхийг зөвлөж байна. Мөн одоо хэрэгжиж буй үүрэг амлалтыг бэхжүүлэх, шинээр үүсч буй тэргүүлэх чиглэлийг тусгах үүднээс Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэхийг санал болгож байна. Энэхүү зөвлөл нь ил тод, олон талын оролцоотой, хариуцлагатай байдлыг хадгалан, тодорхой хугацааны давтамжтай үнэлгээ, зөвлөлдөөн хийх боломжийг олгох ёстой. Ингэснээр Монгол Улс үндэсний хөгжлийн зорилт, олон улсын нээлттэй засгийн зарчимтай нийцсэн илүү идэвхтэй, үр нөлөөтэй засаглалын тогтолцоог бүрдүүлэх боломжтой болно.

---oOo---